


ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1. НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭ, ГАЗАР ЗҮЙН БАЙРШИЛ, ОНЦЛОГЫН ТАЛААР

Сумын түүхэн товчоо

Хэнтий аймгийн Баянмөнх сум нь 1931 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар зарлиг, Ардын засгийн газрын 1931 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 2-р тогтоолын дагуу Дашбалбар уулын хошуунаас биеэ даасан сум, орон нутгийн засаг захиргааны нэгж болон "ХАР ХӨНДИЙ" гэдэг газар



байгуулагдсан.

Сумын төв нь Улаан-Эрэг хэмээх газар байрладаг.



Нутаг дэвсгэр, хил хязгаар

Баянмөнх сум нь Дорнод Монголын тал хээрийн бүсэд багтаж физик газарзүйн мужлалаар хуурай хээрийн бүсэд хамаарч сумын төв нь Хэрлэн голын сав газарт далайн түвшнээс дээш 1110 орчим метр өндөрт Хойд өргөргийн 46 градус 53 минут 81.1 секунд, Зүүн уртрагийн 109 градус 46 минут 27.1 секунд-д Улаан-Эрэг хэмээх газар

байрладаг. Нийт 255385 га нутаг дэвсгэртэйгээс хөдөө аж ахуйн газар 252231 га /үүнээс бэлчээрийн талбай 244167 га, хадлангийн талбай 7400 га, тариалангийн талбай 151 га, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар 513 га, хот тосгон бусад суурины газар 240 га, зам шугам сүлжээний газар 1412 га, усны сан бүхий газар 1501 га, улсын тусгай хэрэгцээний газар 1 га эзэлж байна. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1527 метр өндөр "Их Салхит" уул юм. Сумын нутгийн хойд зах нь Соёгийн худаг, зүүн зах нь Хөх нүдэнгийн худаг, урд зах нь Эргэнэг уул, баруун зах нь Дээд хадан хошуу юм. Улсын нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Чингис хотоос 100 км алслагдсан. Баруун, баруун урд талдаа Дархан сум, баруун хойд талдаа Дэлгэрхаан сум, хойд талдаа Жаргалтхаан сум, зүүн хойд талдаа Мөрөн сум, зүүн талдаа Баянхутаг сум, зүүн урд талдаа Галшар сум, урд талдаа Дорноговь аймгийн Их хэт сумдуудтай тус бүр хиллэдэг.

2. ХҮН АМЫН ТОО, ЯС ҮНДЭС, СОЁЛ, УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫН ОНЦЛОГЫН ТАЛААР

Баянмөнх сум нь 4 баг, хүн амтай бөгөөд хүн амын дийлэнхи хувь нь халх ястан бөгөөд цөөн тооны Дөрвөд, Баяд гарал угсаатай иргэд байна. Соёл ёс заншлын хувьд авч

үзвэл уламжлалт мал маллагаа, хийгээд түүнтэй холбоотой зан заншлын (мал сэтэрлэх, хонь, ямаа, тэмээний хөөвөр авах, хурдан морь уях, унага тамгалах, мал хөнгөлөх,)зүйлсийг хийж гүйцэтгэдэг. Мөн нийт Монголчуудтайгаа адилаар үндэсний баяр наадмаа тэмдэглэн, урин дулаан цагийг угтаж цагаан сарын баярыг тэмдэглэдэг. Уламжлалт тоглоом наадгайнаас авч үзвэл шагай няслах, шагай шүүрэх, бөх барилдах, шагай харвах зэрэгт хүүхэд багачуудыг сургаж хүмүүжүүлдэг. Уламжлалт ардын язгуур урлагийн талаас авч үзвэл Ардын билэг зүйч, ерөөлч, магтаалч, Монгол улсын тэргүүний уран сайхан, Монгол улсын соёлын тэргүүний ажилтан Л. Агваанжамбалын өвлөн уламжлуулсан ерөөл, магтаал, дуу, шүлэг, мөн түүний олон олон шавь нар одоо хүртэл ерөөл магтаал дуудаж, морины цол, бөхийн цол дуудан нутаг орныхоо ард түмэнд уламжлан хүргэсээр байна. Өсвөрийн шагайн харваа эрчимтэй хөгжин улс, бүс, аймгийн тэмцээн уралдаанаас 150 гаруй медаль хүртээд байна.



Баянмөнх сумын Цэцэрлэгийн бөхчүүд



Баянмөнх сумын ЕБСургуулийн үндэсний шагайн харвааны баг
Улсын аврага шалгаруулах тэмцээн

3. СУМЫН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН, ТҮҮНИЙ ОНЦЛОГИЙН ТАЛААР

Дулаан Нөмрөг Хайрхан хоршоо нь 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдөр албан ёсны гэрчилгээ, тамга тэмдэгийг хуулийн хүрээнд авч үүсгэн байгуулагдсан. Тус хоршоо нь эсгий, эсгий эдлэлийн худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. 12 гишүүнтэй, Монгол Тафтинг хивс"-ний орон нутгийн салбар үйлдвэрт 3 ажилтантай үйл ажиллагаа явуулдаг.

2017 онд Канад улсаас Баянмөнх суманд хэрэгжүүлж байгаа ИНВЕСТ Ко-оп Монгол төслийн санхүүжүүлтээр хонь, тэмээний ноосонд нэмүү өртөг шингээх, зардлыг бууруулах, эрүүл ахуй, чанарын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүнээр зах зээлд нэвтрэх боломжийг дэмжиж тус хоршоонд “Монгол Тафтинг хивс”-ний тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлж Тафтинг хивсний орон нутгийн салбар үйлдвэр байгуулагдаж үйл ажиллагаагаа өргөтгөн ажиллаж байна.



4. АМЬТАН, УРГАМЛЫН АЙМАГ, ТӨРӨЛ ЗҮЙЛ, АНГИЛЛЫН ТАЛААР

Газрын гадарга, хөрсний бүтэц

Газрын гадарга нь ухаа гүвээ, толгод, намхан уулс, хотгор бүхий талархаг байдалтай. Газрын гадаргуугийн налуу 1,0-1,5 градус, далайн түвшингөөс дээш 1115-1233 метр өргөгдсөн. Тус сумын хөрсөн бүрхэвчийн хувьд манай оронд хамгийн өргөн тархсан элсэнцэр болон хөнгөн шавранцар хүрэн хөрс зонхилох бөгөөд дунд зэргийн зузаан хар сааралдуу ба хар хүрэн хөрсний ялзмагт давхаргын зузаан нь дунджаар 22-45 см байх

бөгөөд үржил шим сайтай, уулын хөрсний ялзмагт үе давхарга нимгэн, шилжилтийн үе тод бус, их чулуурхаг, давсжилт багатай, ухаа гүвээт тал хөндийн хүрэн хөрс нь үржил шимээр ядуу, харьцангуй нимгэн ялзмагт давхаргатай, гүндээ карбонатлаг болон мараалаг шинжтэй байх нь олонтаа. Харин голын хөндийн аллювийн болон нуга намгийн хөрс нь ялзмагжилт болон бусад үржил шимийн үзүүлэлтээр арай доогуур боловч чийгийн хангамжаар сайн байдаг. Газрын чичирхийлэл 6 балл юм.

Геологийн тогтоц, ашигт малтмал

Хайлуур жонш, Хужир, уран, хар тугалаг, барилгын материалын баялагтай. Хэрээ хөхлийн жонш зэрэг ашигт малтмалтай.

Цаг агаарын нөхцөл байдал

Сумын нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, хоногийн ба жилийн халуун хүйтний хэлбэлзэл ихтэй. Жилийн дөрвөн улиралд унах тунадасны хувиарлалт бага хуурай сэрүүн байдаг. Агаарын температурын олон жилийн дунджаар авч үзэхэд агаарын үнэмлэхүй их температур зуны улиралд +25, үнэмлэхүй бага температур өвлийн улиралд -20, хур тунадасны жилийн дундаж хэмжээ 80 мм, салхины жилийн дундаж хурд метр секунд байх ба зонхилох салхины чиглэл баруун өмнө зүгээс байна.

Гадаргын болон гүний усны нөөц

Сумын төв нь усан хангамжаар сайн, хөрсний усны төвшин 5,4-7,8 м. Нийт нутаг дэвсгэрийн 0,59 хувийг усны сан бүхий газар эзэлдэг. Хэрлэн гол, Цэнхэрийн гол, Барчгар, Хавчуу, Могой, Агуйт, Булингаа, Гүн бүрд зэрэг нуур, булгууд бий.

Хэрлэн гол: Хэнтий нуруунаас эх аван урсах монголын хамгийн урт гол болох Хэрлэн гол нь сумын нутгаар нийт 100 гаруй км урт үргэлжлэн урсах Гидрокарбонат, натрийн найрлагатай Баянбулагийн рашаан бий.

Ургамал, амьтны аймаг

Ховор амьтдаас тоодог, галуу, бусад амьтдаас цагаан зээр, үнэг, хярс, мануул, дорго, туулай, тарвага, чоно болон шонхор, сар, шар шувуу зэрэг жигүүртэнүүд, тусгай хамгаалалтай амьтан Угалз, Хонь, Халиун буга зэрэг амьтад идээшилэн амьдарч байна.

Байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газрууд

Тус сумын нутаг байгалийн үзэсгэлэнт Язаар ууланд : Дэлгэрцогтын агуй, Сэнжит хад, Их агуй, Бага агуй, Хуниастын агуй, Гурван овоот, Солби зэрэг үзэсгэлэнт газрууд байдгаас гадна өвөл зунгүй ундран урсдаг Алдарт Баянбулгийн рашаан байдаг. Мөн хулжийн хужир, Хар хөндийн Гүн бүрд нуур, Баянцогтын булан зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд олон бий.

Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрууд:

Хүн чулуу: Баянцагаан талын хүн чулуу, Гүн бүрдийн хүн чулуу 1,2, Түрэгийн үеийн хашлага чулуу 1,2,3,

Чулуун зэвсгийн бууц суурин: Ханангийн палеолитийн дурсгал, Хар усны чулуун зэвсгийн суурин,

Хадны зураг: Агуйт уулын зосон бичээс, Сэнжит хад,



Булш, Хиргисүүр: Алтан өлгийн хиргисүүр, Баян булагийн дөрвөлжин булш, Баян цагааны энгэрийн булш, Баянцогтын дөрвөлжин булш, Холбоо уулын ар, өврийн дөрвөлжин булш, хиргисүүр

Сүм, хийд туурь: Баянмөнхийн хийдийн туурь, Доржсэмбий хийдийн туурь, Зоригт хошууны хийдийн туурь, Хар хөндийн хийд, Мандалын хийд, Хэрээ хөхөлийн хийд

Хөшөө чулуу: Холбоо уулын хөшөө чулуу, Дулаан Богины хөшөө чулуу

Агуй: Агуйт уулын агуй зэрэг түүх соёлын дурсгалт газрууд бий.

АГУЙТ УУЛЫН АГУЙ: Сумын төвөөс баруун урд зүгт 30-аад км-т Агуйт гэх ханан хадтай уул бий. Энэ уулын ханан хадны хормойд чулуугаар өрж хаалга гаргасан жижиг агуй байдаг. Тус агуйд дээр үеэс лам нар сууж даяан хийдэг байжээ. Энэ агуйд хүний гавлын ясаар хийсэн хоёр ширхэг аяга байдаг байсан ба өдгөө тэр аяга алга болсон ба агуйн дотор хананд зориуд зассан гэмээр индэр дээр ном, судар, шашны хэрэглэгдэхүүн л үлдсэн байна.

СЭНЖИТ ХАД: Энэ хад нь Агуйт ууланд байх ба өвөрмөц тогтоц бүхий уулын орой дээр дэллэн тогтсон ханан хад байдаг. Хадны дунд талд алсаас харахад дундаа зайтай сэнж бүхий нүхтэй харагддаг.

БАЯНБУЛАГ РАШААН: 1940-өөд оны дунд үеэр болсон өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын цугларалтаар хэдэн зуун хүн агт морьдыг төвөггүй ундаалж байсан, өвөл зунгүй ундрал урсдаг алдарт рашаан юм. Нутгийн иргэд ходоод гэдэсний өвчинд тустай хэмээн эмчилгээний журмаар хэрэглэдэг уламжлалтай.

ХУЛЖИЙН ХУЖИР: Дархан Баянмөнх сумын нутгийн зааг дээр хулжийн бүрд хэмээх дэрстэй хоолойд эрт үеэс уламжлан ашиглаж ирсэн амны хужир байдаг. Нутгийнхан энэ хужраас авч хэрэглэдэг заншилтай ба хулжийн хужир нь эрүүл мэндэд сайн нөлөөтэй гэдгийг хүн бүр мэдэх бизээ.

ХАР ХӨНДИЙН ГҮН БҮРД НУУР: Хар хөндийд байдаг нэгэн нуурыг Гүн бүрд гэдэг. Адуу шахаад оруулахад үүдэн хойморын хэртээ яваад хөл алдаж, хоёр чихний үзүүр, хамар нь харагдах төдий болоод дороо эргэдэг юм.


Хэнтий аймагт хөхтөн 5 баг 17 овог 70 зүйл тэмдэглэгдсэнээс шавьж идэштэн 8 зүйл, сарьсан далавчтан 6 зүйл, туулай хэлбэртэн 4 зүйл, мэрэгчтэн 28 зүйл, махан идэштэн 17 зүйл, туруутан 7 зүйл бүртгэгдсэн. Баянмөнх суманд тархан нутагшдаг амьдын ерөнхий шинжүүд:

Амьтныг биетээр харах боломж хомс тул ул мөр, баас, хэвтэр, идэнгшээр нь тухайн газарт байгаа эсэхийг болон зүйлийгч тогтоох боломжтой.



Мөрийг дурын гадаргаас илрүүлэх боломжтой бол, харин баас нь тухайн амьтны зан төрх, экологиос хамааран илүү элбэг эсвэл бүр олдохгүй ч байж болно. Монгол орны хуурай гандуу цаг уурын нөхцөлөөс хамааран зарим газар амьтны яс сайтар хадгалагдан үлдэх боловч, зарим газар, тухайлбал, хээр говь цөл нутагт өгөршил хурдацтай тул амар хялбар олдохгүй байх боломжтой. Жижиг хөхтөн амьтдын толгойн яс болон шүд нь тэдгээр амьтдыг тодорхойлох хамгийн чухал бодит эд мөрийн баримт болдог.

Хөхтөн амьтдыг мөрөөр таних /туруутан/



Хөхтөн амьтдыг мөрөөр таних /жижиг мэрэгчид, махчин амьтад /

Хөхтөн амьтдыг эвэр болон соёогоор таних/туруутан/



Хүйсийг эвэр болон соёогоор ялгах амьтдад:

Аргаль-угалз/угалзан эвэртэй/

Цаган зээр-ооно/эвэртэй/

Бор гөрөөс-гур/э вэртэй/

Халиун буга-буга дайр/эвэртэй/

Хандгай-мэнж/эвэртэй/

Баданги хүдэр-гирээ/соёотой/

Зэрлэг гахай-бодон /соёотой/

Халиун буга – *Gervus elaphus* (Linnaeus, 1758)

Орос нэр – Марал

Англи нэр – Red Deer or Elk



Биологи: Буганы нялх төлийг ил, эрийг буга , эмийг согоо, хоёр настайг зоргол буга, гурван настайг шуумгай дайр , 4 настайг цох 5 настайг жин буга гэж нэрлэдэг. Бугын биеийн урт 180-240 см, сэрвээний өндөр 115-150 см , жин 100-300 кг. Буганы зүс нутаг бүрд яльгүй өөр өөр байх боловч ерөнхийдөө өвөл хөхөвтөр буюу цайвар халиун , зун хүрэн байдаг. Буга 5-аас дээш салаа нарийвтар эвэртэй , согоо эвэргүй . Буга нарийн өвс , модны мөчир нахиа авч хаг , хөвд, мөөг иднэ. Ороо нийллэг нь 9-р сарын 10-15 нд эхэлж сар орчим үргэлжилдэг. Орооны үед бугын дуудлагын үеэр эр амьтдын тэмцэл болдог. Нэг буга 3-8 согоо хурааж хээлтүүлдэг. Буга 20, согоо 30 хүртэл тоо толгойгоор сүргэлдэг. Буга өвлийн цагт зузаан цаснаас зайлж ойн дээд , тагийн бүс хүртэл өгсөж бэлчээрлэнэ. Согоо хээлээ 240-250 хоног тээж 6 дугаар сарын эхээр төллөдөг. Жил бүрийн 3-4 сард ясан эвэр унана.

Монгол улсын засгийн газрын 2012 оны 7 тоот тогтоолоор Ховор амьтны зэрэглэлд оруулсан.

Баянмөнх сумын нутагт Халиун бугын тархан идээшилдэг нутаг Баянбулаг багийн Язаар уул орчим, Дархан уул хооронд нүүдлэн тархсан байна. Тоо толгой Язаар уул орчимд 3 халиун буга тархан нутагшиж байна. Язаар уул орчмыг 2016 онд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар “Орон нутгийн тусгай хамгаалалтанд ”оруулсан. Тусгай хамгаалалтанд авснаар уул уурхай болон ямар нэгэн хууль бус зөрчиллөөс хамгаалан түүнд идээшин нутаглаж байгаа ховор , болон ховордсон амьтдыг хамгаалахад гол зорилго оршино.



Баянбулаг багийн нутаг Язаар ууланд тархан нутагшиж байгаа Халиун буга

Аргаль угалз –Ovis ammon (Linnaeus 1758)

Орос нэр- Горный Баран

Англи нэр – Argali or Wild Mountain Sheep



Биологи: Аргалийг эрийг угалз, эмийг аргаль, төлийг хурга гэдэг. Угалзын биеийн урт 140-180 см, сэрвээний өндөр 100-125 см, жин 110-200 кг, аргалийн биеийн урт 130-160 см, сэрвээний өндөр 95-115 см, жин нь 80-100 кг хүрдэг. Угалз хүчирхэг том угалзсан эвэртэй, аргаль богино жижигхэн эвэртэй. Алтайн аргаль Монгол оронд байгаа бүх зүйлийн аргаль угалзнаас бие эвэр, толгойн хэмжээгээр хамгийн том юм. Аргаль уулын өтгөн өвстэй зоо

нуруу , уулын задгай хээр хад асга багатай толгод орчмоор бэлчээрлэнэ. Олон зүйлийн өвслөг бутлаг ургамлын ногоон хэсэг, цэцэг навч иш хялгана улалж сонгино мангираар зонхилон хооллодог. Аргаль 2,5-3 настай бие гүйцэж үржилд ордог. Угалз таван настайгаасаа эхлэн ороо хөөцөлдөөнд орж 10-20 аргаль хурааж өөрийн хуй сүрэгтэй болно. 11 дүгээр сарын эхээр нийллэгт орж 5.5 сар хээлээ тээнэ. Гол дайсан нь чоно, ирвэс хурганы дайсан нь бас бүргэд юм. Манай оронд 1953 оноос эхлэн агнахыг хориглож Засгийн газрын шийдвэрээр Ховор ан амьтдын зэрэглэлд оруулсан. Монгол орны хөхтөн амьтны Улаан дансанд тус тус бүртгэгдэж , тархац нутгийн 14 орчим хувь нь тусгай хамгаалалттай газарт хамрагджээ. Баянмөнх сумын нутагт Баянбулаг багийн нутаг Язаар уул орчимд Угалз 2-4 толгой, Хомь 40-48 толгой , хурга 10-16 толгой орчим тархан нутагшиж байна. Язаар уул орчмыг ан агнуурын бүс байгуулан хариуцагч нь Монгол Сафари ХХК хариуцан ажиллаж байна. Ан амьтдын тоо толгой тэдгээрийн өсөж үржих болон биотехникийн арга хэмжээ авах үйл ажиллагааг хариуцан хамтран ажиллаж байна.



Баянбулаг багийн Язаар ууланд суурьлуулсан камерын зураг

Саарал чоно – Canis Lupus

Орос нэр – Волк

Англи нэр – Gray Wolf



Биологи: Биеийн урт 105-160 см сүүл 30-50 см эр чоно 35-40 кг жинтэй байдаг. Шар туяатай , бараан саарал зүстэй , жижгэвтэр биетэй чоно, монгол оронд тархсан . Бүх бүсэд чоно тархсан боловч 1000 гад 1-2т чоно тохиолдоно. Жилд нэг удаа ороо хөөцөлдөө нь 1-2 дугаар сард болж нийллэгээс хойш гичий 62-65 өдөр хээлээ тээж 4-5 дугаар сард 3-4 заримдаа 10-13 орчим бэлтрэг төрүүлнэ. Чоно 10-12 жилд хөгширч, амьдралын дээд хугацаа 15-20 жил үргэлжилнэ. Мал аж ахуй, зэрлэг ан амьтанд гарз хохирол учруулдаг хамгийн хөнөөлтэй махчин амьтан юм. Сумын хэмжээнд саарал чоно бүх багийн нутгаар тархан нутагшидаг. БОНХ-ийн сайдын 2014 оны А-61 тоот тушаалаар Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутагт чоно агнахыг 2014 оны 02 дугаар сарын 25-наас дахин 3 жилийн хугацаагаар хориглосон. Сумын хэмжээнд Саарал чоно Баянбулаг, Хэрлэн , Дулаан багийн нутагт харилцан адилгүй тархан идээшилж байна. Саарал чоно жил бүрийн 01 сард үргээлгэнд явах нэрийдлээр маш их хэмжээний чоно устгаж байна. Хяналт шалгалтыг маш сайн явуулах шаардлагатай байна. Үүнд байгаль орчны ажилтнуудаас гадна, ард иргэд идэвх санаачлагатай мэдээлэл солилцох хамтран ажиллах шаардлагай.

Тарвага – Marmota Sibirica

Орос – Монгольский сурок
Англи – Siberian barmot



Биологи : Биеийн урт 37-63 см , сүүл нь 9-19 см . биеийн ерөнхий зүс элсэн шаргалаас хар , халтар толгойн дээд хэсэгт хар , сүүлний төгсгөлийн дээд тал хар хүрэн өнгөтэй, тарвага өвслөг ургамал ихтэй уулын бэл , голын хөндийгөөр нутагладаг. Үдийн халуунаас бусад үед өдрийн турш бэлчээрлэнэ. Төрөл бүрийн өвслөг ургамлын навч цэцэг иш цох дэвхрэг зэргээр хооллоно. Амьдралын ихэнх хугацааг нүхэнд өнгөрөөдөг тарваганы нүхийг тогтмол , түр зуурын гэж хоёр хэсэгт хувааж үзнэ. Тарвага бүлээрээ амьдардаг нүхийг тогтмол нүх буюу ичээ гэж ялгана. Ичээний нүхний урт 5-20 м , нүхний амсрын диаметр нь 25-30 см орчим байна. Хавар ичээнээс гармагц ороо хөөцөлдөө нь эхлэн нэг сар орчим үргэлжилнэ. Эмэгчин тарвага 5-6 дугаар сард 3-6 мөндөл төрүүлнэ. Мөндөл төрснөөс хойш бүтэн сар эхийн сүүгээр хооллоно. 5-8 дугаар сард гуужиж үсэн бүрхүүл нь солигддог .Тарваганы эрийг Бурхи, эмийг Тарч, төлийг Мөндөл гэж нэрлэдэг.Дайсан амьтан нь нохой , үнэг , чоно, хяррс , зарим шувууд мөн хүн болно.

Хэнтий аймгийн Баянмөнх сумын нутгаар тарвага Баянбулаг, Хэрлэн, Дулаан багийн зарим газар нутгаар тархан идээшин амьдарч байна. Байгаль орчны сайдын тушаалаар 2005 оноос одоог хүртэл монгол орон даяар тарваганы агнуурын бүр мөсөн хориглосон боловч агнуурын нөхцөл үргэлжилсээр л байна. Монгол орны хөхтөн амьтны улаан дансанд бүртгэгдсэн. Манай нийт нутгаар жил бүрийн аравдугаар сарын 16-наас дараа оны наймдугаар сарын 20 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар хоригложээ.

ЦАГААН ЗЭЭР –Pricapra gutturosa

Орос нэр – Монгольский Дзерен

Англи нэр – Mongolian of White – tailed Gazelle



Биологи: Гадаад байдлаараа хар сүүлт зээртэй нилээн төсөөтэй . Биеийн урт нь 100-145 см сэрвээний өндөр 54-58 см , биеийн жин эрийнх нь 40-45 кг, эмийнх нь 30-32 кг, хүдэг. Богино цагаан сүүлтэй , эмд нь эвэр байдаггүй, эр нь эвэртэй бөгөөд 180-200 мм хар бор өнгөтэй байдаг. Цагаан зээрийн хөөцөлдөөний үе 12 дугаар сараас эхэлж 1 дүгээр сар дуустал үргэлжилнэ. Шаргачин хээлээ 5-6 сар тээж 6 дугаар сарын сүүлч 7 дугаа сарын сүүлчээр голдуу сөнгө янзага гаргана. Намрын гуужилт нь 9 дүгээр сард эхэлж 10 дугаар сард өвлийн үснэ гүйцэд ургана. Цагаан зээр ихэвчлэн олон тоогоор сүрэглэн амьдрах бөгөөд намар 100 –гаас дээш заримдаа хэдэн зуугаар сүрэглэн амьдардаг. Хээр цөлөрхөг , хээрийн бүсэнд хялгана агь дэрс өлөн хиаг зэрэг ургамлаар хооллоно. Албан ёсны агнуурын тооноос хууль бус агнуурын хэмжээ хэд дахин давж өргөн хүрээгээр агнадаг нь ховордлын гол шалтгаан болдог. Амьтны тухай хуулиар жил бүрийн 12 дугаар сарын 01 – нээс дараа оны 08 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хуулиар хоригложээ. Манай нийт нутгаар жил бүрийн 12 сарын 01 – нээс дараа оны 8 сарын 31 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар хоригложээ. Зөвшөөрлийг 9 сарын 01- 12 сарын 01 хүртэлх хугацаанд нэг толгойг 100000 төгрөгөөр сумын Байгаль хамгаалагч олгож байна. Хууль бусаар агнасан тохиолдолд иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин , Засийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан Ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээ тогтоосон. Ооныг – 500000 төгрөгөөр , Шаргачинг 550000 төгрөгөөр, Эр янзагыг 350000 төгрөгөөр , эм янзагыг 385000 төгрөгөөр тус тус үнэлээд байгаль орчны хяналтын улсын байцаагчийн актаар уг үнэлгээг 2 дахин өсгөн нөхөн төлүүлнэ. Сумын хэмжээнд Цагаан зээрийн тархан идээшин амьдарч байгаа газар нутаг Баянбулаг, Хэрлэн , Дулаан багийн зарим нутгаар тархан нутагшиж байна. Баянбулаг багийн Язаар ууланд цөөхөн хэдэн цагаан зээр нутагшин идээшилж байна.

ШАР ҮНЭГ – *Vulpes vulpes*

Орос нэр - Лисица

Англи нэр - Red Fox



Биологи : Үнэгний өнгө зүс нь газар зүйн байдал , мөн улирлаас шалтгаалж ялгаатай байдаг. Урт нарийн хоншоортой , өндөр шовх чихтэй уртавтар биетэй харьцангуй богино мөчтэй боловч хурдан шалмаг хөдөлгөөнтэй сагсгар урт сүүлтэй биеийн урт нь 60-90 см сүүл нь 40-60 см элэгчин үнэг 4-8 кг , эр үнэг 5-10 жинтэй биеийн өндөр дунджаар 50-60 см өвөл үс хөрс нь гүйцэж шаргал болдог. Хад чулуутай уулын бэл энгэр гол горхийн хөндий , тэгш тал гүвээ толгодын ар өвөрт тохиолдоно. Хээр хээржүү болон тагийн бүсэд тархан амьдардаг үнэгний хоол тэжээл бол хулгана хэлбэрийн мэрэгчид болно. Соргог үнэрч амьтан тул цасан дор хулгана дугарах , хөдлөхийг мэдэж ганц хайхалтаар цасыг ярж барина. Үнэг өдөрт 10-15 хулгана, оготно устгаж жилд 3000 –аас доошгүй барьж иддэг. Үнэгний нүхний урт ойролцоогоор 10 м орох гарах амсар 2-3 амсар байх бүхий нүхний диаметр 25-30 см байна. Жилд нэг удаа үржинэ. Эмэгчин үнэг 45-58 өдөр хээлээ тээж 4 дүгээр сарын эхээр 4-5 заримдаа 12-14 гавар төрүүлдэг. Үс нь жилд нэг удаа гуужина. Монгол орны хөхтөн амьтны Улаан дансанд ховордож болзошгүй амьтны жагсаалд бүртэгдсэн. БОНХ-ийн сайдын 2014 оны А -61 тоот тушаалаар шар үнэгийг 2014 оны 02 дүгээр сарын 25-ны өдрөөс дахин 3 жилийн хугацаагаар нийт нутагт агнахыг хориглосон . Мөн жил бүрийн 2 дугаар сарын 11-нээс 11 дүгээр сарын 20 хүртэлх хугацаанд агнахыг Амьтны тухай хуулиар хориглосон. Баянмөнх сумын хэмжээнд Хэрлэн багийн нутгаар арай илүү тархан идээшилж байна. Баянбулаг, Дулаан багийн зарим газар нутгаар бага зэрэг идээшлэн суурьшсан байна.

Овог –Шонхорынхон

Идлэг шонхор – *Falco cherrug* (Gray 1834)

Орос нэр - Балобан

Англи нэр – Saker Falcon



Биологи : Түргэн хархираа Монгол Алтайн нурууны дагуу ховд голын эхнээс Булган , Үенчийн гол тайшир , их богд , Тэс гол, Дэлгэр мөрний дунд хэсэг, идэр Чулуут улз Туул Хэрлэн Онон болон Эгийн гол буйр халх гол нөмрөгийн ай савд тархжээ. Төгөл бургас шугуйтай хөндийд амьдарна.

Эм шонхор эрээсээ арай том биетэй байх ба эр шонхорын биеийн урт 42-50 см , эм шонхорын биеийн урт 52-59 см эрийн далавчны дэлгэц нь 104-114 см эм нь 120-120 см байдаг. Эрийн жин 820-890 гр , эм нь 970-1130 гр хүрдэг. Өд сөд нь цайвар хүрнээс хар бараан зүстэй байх ба цээж хэвлий гуяны хучигт өдөндөө хар бараан харавтар толбонуудтай . Сүүлэндээ цайвар бараан хөндлөн судлуудтай . Эмийнх нь зүс эрээсээ арай бүтгэвтэр байна. Залуу идлэг шонхорын хошууны уг хөл савар нь шар сүүл богино толбо цөөхөн зэрэг шинж тэмдгээр ялгагдана. Заримдаа хааяа цав цагаан шонхор үзэгдэнэ. Шонхорын төрлийн шувуудыг хошууны доод ирмэгт байх соёо хэлбэрийн махираар товгороор бусад махчин шувуудаас амархан ялган таньдаг. Идлэг шонхорын бусад төрлийн шувуудаас харьцангуй том байдгаараа ялгаатай. Нүүдлийн махчин шувуу юм. Гол тэжээл нь огтоно, хулгана , зурам, үлий зэрэг болно. Залуу идлэг шонхор шувууны нуруу бараан хүрэн нарийн улбар эмжээр бүхий өдтэй. Дагзны өд нь цайвар бөгөөд хар голчтой дэвүүрүүд улбардуу дотор талаасаа мөн улбардуу толбо бүхий эрээн залуур бараан хүрэн хөндлөн судалтай үзүүр цагаан 10 сартайд үржилд орж хус бургасан төгөлд үүрээ засч 6 дугаар сарын эхээр 5-6 ширхэг улбардуу хүрэн толботой өндөг гарган нэг сарын дараа ангаахай гарна. Тусгай зөвшөөрөл гэх нэрийн дор замбараагүй амьдаар барьж гадаадын хээнцэр баячуудад хэтэрхий бага төлбөртэйгээр гаргасаар байна. Мөн амьдаар нь барихдаа осолдох явдал цөөнгүй. Засгийн газрын 2013 оны 15 тоот тогтоолоор идлэг шонхор шувууг ашиг олох зорилгоор гадаадад гаргахыг 2013 оны 01 дүгээр сараас эхлэн 5 жилийн хугацаагаар хориглосон боловч Засгийн газрын 2013 оны 92 дугаар тогтоолоор батлагдсан 2013 онд агнах барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай нэмэлт өөрчлөлт оруулан мөн газрын 2013 оны 297 тоот тогтоолоор 20 хүртэлх толгой шонхор шувууг гадаадад нэмж гаргахыг БОНХЯ –нд зөвшөөрсөн байна.

Овог – Нугасныхан

Гангар хун – Cygnus Cygnus

Орос нэр -Лебедь кликун

Англи нэр – Whooper Swan



Биологи: Говийн их дархан цаазтай захуй зармангийн говь , цагаан шал буурлын хард дүүлж өндөглөдөг ба дайрч буудаллан өнгөрнө. Нүүдлийн нэн ховор усны үзэсгэлэнт төгөлдөр шувуу . Зүс цав цагаан хүзүү урт хошууны үзүүр хар уг шаргал хөл хар сэлэхэд зохилдон сарвуунууд нь сарьсаар холбогдсон. Гангар хун чанга уянгалаг гангасан дуугаараа бусад хунгаас тод ялгардаг. Соргог хурц хараатай биеийн жин 10-12 кг хүрдэг. Эр эмээр хослон амьдардаг. Үзэсгэлэнт энэ зүйл шувуу ямагт бие биетэйгээ ойролцоо байж чанга гангасан дуугаараа хоёр биендээ болон үр төлдөө чимээөгч харьцаж байдаг онцлогтой. Гангар хун монгол оронд 3 дугаар сарын дунд 4 дүгээр сарын эхээр ирж үүрлэн өндөглөн зусч үр удмаа байршуулаад 9 дүгээр сарын дундаас 10 дугаар сард дулаан оронд очиж өвөлжөөд төрөлх нутагтаа хавар эргэж ирдэг юм. Төрлөх нутагтаа эргэн ирж зусч үрждэг. Нүүж ирснээс хойш 1-2 долоо хоногийн дараа өндөр өвс ургамал зэгс бүхий ус голын эрэг хөвөө арал голын адгийн ил задгай намагт ургамлын иш хагд өвс зэгс овоолж том сондуул маягийн 3-5 м голчтой , 0,5-1 м өндөртэй үүр засдаг. Үүрнийхээ хэвтрийг хөвд ургамлын ишээр зулж цээж хэвлийнхээ өднөөс зулгаан зөөллөн дэвсэж 4 дүгээр сарын эцэст ,5 дугаар сарын эхээр 5-6 ширхэг , 33-36 гр том цагаан цайвар цагаан , саарал өндөг гаргаж эх өндөгөө 35-40 хоног дарж дэгдээхэй болгох ба 8 дугаар сарын дундуур дэгдээхэй нисч эхэлдэг. Хүчирхэг том биетэй тод цагаан зүс, гангасан чанга дуунаас сүрдэн ихэнх амьтан түүнд болон үүр өндөг дэгдээхэй байршил нутагт нь халдан довтлох нь ховор . Дэгдээхэйнүүд усны жижиг амьтныг идэж хурдан бойжиж томордог.

Овог – нугасныхан

Халзан ангир – *Tadorna terrugin-a* (Pall)

Орос нэр – Мандаринка

Англи нэр – Mandarin duck



Биологи: Монгол улсын цөл говь , хангайн жижиг нуур гол горхи бэсрэг нам уулсаар хавар 3 дугаар сараас 9 дүгээр сарын сүүлч хүртэл тархан байрлаж үүрлэн өндөглөн зусдаг насаараа хослон амьдардаг нүүдлийн шувуу. Тод улаавтар шаргал зүс амьдралынх хэлбэрээр нь монголчууд лам шувуу хэмээн нэрлэж түүнийг агнадаггүй заншилтай. Усны шувуудаас манай оронд хамгийн түрүүнд 3 дугаар сард ирж өндөглөн зусч хожуу буцдаг элбэг шувуу . Өндөглөх үедээ уснаас холдон ууланд очиж байрладаг онцлогтой. Толгой цайвар бор шаргал өнгөтэй. Нуруу хэвлий саарал зээрд сүүлний дээд ба залуур өд хар далавчны дээд бүрхүүл цагаан далавчиндаа тод ногоон тольтой далавчны үзүүр хошуу хөл хар өнгөтэй. Далавчны урт 31-40 см, жин 1-1,6 кг . Нүүдэллэн ирсний дараахан голын хөндий нуур тойрмын эрэг уснаас зайдуухан 2 долоо хоног орчим хосоороо эвцэлдэнэ. Ингэж эвцэлдсэн газраасаа 2-3 км холдож тал хээрийн хад чулуутай бэсрэг уулс модтой ууланд гарч мод чулууны хонгил бусад амьтдын орхисон нүхэнд үүр засахдаа түүндээ төрөл бүрийн зөөлөн өвс өөрийн хэвэл цээжний өд ноолуурыг зулгаан дэвсэж өндөглөхөд бэлтгэнэ. Зориуд засаж бэлдсэн тохилог үүрэндээ 7-10 өндөгийг өдөр өдрөөр цувруулан гаргана. Заримдаа 20 өндөг гаргах нь бий. Ангирын өндөг ягаан туяатай . Үүр өндгөө зөвхөн эм нь 25-30 хоног тогтмол дарж дэгдээхэй болгох ба эр нь байнга манаж хамгаална. Ангирын дэгдээхэй 09 дүгээр сарын сүүлч , 7 дугаар сард үзэгдэн 8 дугаар сард нисч эхэлнэ.

Монгол улсын амьтны тухай хуулиар жил бүрийн 04 дүгээр сарын 20-ноос 08 дугаар сарын 31, мөн 10 дугаар сарын 20-ны өдрөөс дараа оны 03 дугаар сарын 31 ний өдрүүдэд агнахыг хориглосон.

Овог нэр – Гургуулынхан

Дагуурын ятуу – *Perdix dauurica*
Орос нэр – Бородатая Куропатка
Англи нэр - Daurian partridge



Биологи: Дагуурын ятуу монгол алтан хан хөхий Тарвагатай булнай байдаг хавтаг тахийн шар нуруу бүрэнхий нуруу хорьдил сарьдаг бүтээлийн нуруу хэнтий хянганы салбар уулын бэл , Бөх мөрөн, Ховд , Булган , Тэс , Мөрөн , Завхан , Түйн гол , Орхон , Сэлэнгэ , Ерөө, Хараа, Туул , Хэрлэн , Онон , Улз, Халх голуудын сав газруудад болон уулархаг хээр говирхог хээрийн бүсүүдээр тархалттай гэж тэмдэглэгджээ.

Тахианы багийн шувуу биеийн хэмжээгээр тагтаанаас арай бага жингээр 300 гр байна. Нурууны талын өнгө цайвар хүрэн саарал хөндлөн тод хүрэн судлуудтай. Далавчны дээд талын өдүүд тууш цагаан судлуудтай цээж гүеэ эрүү хацар хөмсөг нь улбар шар өнгөтэй хэвлийдээ том хар толботой. Нүдний догуур хөндлөн хар зурвастай байна. Сүүлний өдний дунд хоёрын нэгээс бусад нь хүрэн улаан өнгөтэй. Дагуурын ятуу тал хөндий жижиг аараг толгод уулын бэл сөөг бут бүхий газар амьдарна. 3 дугаар сарын дундуур ороо нь орж эр эмээрээ сүргээр хос хосоороо тасран 4 дүүгээр сарын сүүлч 5 дугаар сарын эх хүртэлх хугацаанд бургас бутлаг ургамлын ёроолд үүрээ засч 12-20 хүрэндүү туяатай өндөг гаргадаг. Эмэгчин ятуу нь гурван долоо хоног дарна.

Амьтны тухай хуулиар дагуурын ятууг 03 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 31 нийг хүртэлх хугацаанд агнахыг хоригложээ.

Овог – хулдыхан

Зэвэг – *Brachymstax lenok* (Pallas 1773)

Орос нэр – Ленок

Англи нэр – Lenok



Биологи : Сэлэнгэ , Ерөө , Туул , Дэлгэр , Мөрөн, Эг, Суман, Идэр, Чулуут, тамир, Орхон, гол тэрхийн цагаан нуурт түгээмэл тархжээ. Энэ зүйл загс өндөр газарт орших нуур болон хүйтэн устай голуудыг шүтэж амьдардаг. Хүчилтөрөгчөөр баялаг уулын ширүүн урсгалт гоьлн харгиа хэсэгт амьдарна. Зэвгэ холимог идэштэн. Бие гүйцсэн зэвгийн урт 70 см , жин 6 кг хүрдэг.Зүс алтлаг бор вмуу алтлаг бараан байх ба үржлийн үед биеийн өнгө улаавтар туяатай болох ба хэвлий сэлүүрүүд солонгорсон янз бүрийн өнгөтэй байна. Биеийн гадаргуу толгойн дээд хэсгээр гол төлөв дугариг хэлбэрийн тод бараан толбуудтай. Нуруун талд сүүлний сэлүүрийн өмнө өөхөн сэлүүр бий. Бие хоёр хажуугаасаа хавчиг ам жижиг тэгш, хэвлий болон хоолойн хэсэг жижиг хайрсаар бүрхмэл . Зэвэг 5-6 насандаа бэлгэ боловсорч 5 дугаар сарын эхээс 6 дугаар сар хүртэл усны температур 8-12 хэм болох үед голын хайрга , чулуутай жигд урсгалтай хэсэгт 2,8-5,5 мянган түрсээ гаргана. Далай тэнгисээс алслагдсан тул хол нүүдэл хийхгүй үрржил болон өвөлжих үедээ нуураас гол голоос нуур руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн хийдэг. Зэвгэ элдэв идэштэн загас бөгөөд бие гүйцсэн үедээ шавьж түүний авгалдай шаамий хавч жижиг загас мэлхий хулгана түүнчлэн хулд загасны түрсээр хооллодог. Монгол улсын улаан номонд бүртгэгдсэн бөгөөд зэвгийг Амьтны тухай хуулиар жил бүрийн 04 дүгээр сарын 01-нээс 06 сарын 01 хүртэлх хугацаанд барихыг хориглосон.

Овог – Мөргийхэн

Булуу цагаан – *Cyprinus rubrotusuc*

Орос нэр – Амурский Сазан

Англи нэр – European or Mirror or Amur Carp



Биологи: Амар мөрний унаган загас. 1936 онд байгаль нуурын орчим нутагшуулсан. Сэлэнгэ мөрнөөр дамжин манай Орхон , Туул , Өгий нуур, Хэрлэн , ОРШуун гол Буйр нуурт тархжээ. Бие гүйцсэн булуу цагаан загасны биеийн урт 1,2 метр, жин 16 кг хүрдэг. Нуруу боровтор хүрэн хайрсны захаар бараан эмжээртэй , хажуу тал нь алтлаг шаргал өөхийн хэсэг шаравтар туяатай цайвар өнгөтэй.

Хос богино сахалтай нурууны сэлүүр урт, гурван эгнээ залууртай араатай хайрс том захаараа бараан эмжээртэй , бие махлаг бүдүүн сэрвээгээрээ урт эхний хатгуур цацраг хэлбэртэй, ясархаг шүдтэй хайрс нарийн хар эмжээртэй юм шиг үзэгдэнэ . голын цүнхээл тогтуун хэсэгт нууранд амьдарна. 3-4 насандаа биеийн урт 29-35 см хүрэхэд бэлгэ боловсорч 6 дугаар сарын эхээр 19-22 хэмийн дулаан усанд ургамал бүхий хэсэгт 348 мянгаас 1,8 сая түрс гаргана. Холимог идэшт загас . Жараахай шатандаа хөвөгч амьтад, ёроолын шавьжийн авгалдай зөөлөн биетэн , шумуулын авагалдайгаар бие гүйцсэн үедээ усны ургамлаар зонхилон хооллоно. Замбаараагүй хайр найргүй хууль бусаар хулгайгаар барих нь буурахгүй байгаа нь ховордох гол шалтгаан болов. Орчны бохирдол, хомсдол энэ зүйлд аюул учруулж байна. Булуу цагаан загасыг 2006 онд Монгол улсад загасны улаан дансанд оруулсан ба энэ зүйлийн тархалт тус орны нутаг дэвгэрийн 1-ээс бага хувийг эзэлдэг учир үнэлэх боложгүй зэрэглэлээр үнэлжээ. Монгол улсад булуу цагаан загасыг Амьтны тухай хуулиар жил бүрийн 04 дүгээр сарын 01-нээс 06 сарын 01 хүртэлх хугацаанд барихыг хориглосон.

Овог – Мөргийхэн

Мөнгөлөг хэлтэг – *Carassius gibelio*

Орос нэр – Серебряный Карась

Англи нэр – Golden / Chinese / carp



Биологи: Хангай нурууны хойд мөсөн далайн ай савын Орхон гол, Өгий, Буйр, Онон, Хэрлэн, Тэрхийн Цагаан нуурт амьдардаг.

Онон, Хэрлэн голууд, Буйр нуур, Сэлэнгэ мөрөн, Хөвсгөл нуурыг зүүн хэсгээр тархсан гэх боловч популяцийн үнэлгээ хийгдээгүй. Нуруу ногоовтор бараан хажуу мөнгөлөг хайрс том маш нягт захаараа бараан эмжээртэй нурууны сэлүүр урт ам тэгш нэг эгнээ залгиур араатай биеийн урт 65 жин 1 кг хүрнэ. Ихэвчлэн цэнгэг усанд оршдог нилээн өргөн тархацтай баг юм. 3 настайдаа биеийн урт 11,5-22 см хүрэхэд бэлгэ боловсорч 5 дугаар сарын сүүлчээр усны температур 14-16 хэм болоход ургамал бүхий хэсэгт 16,0-400 мянган түрсийг хэсэг хэсгээр шахаж эхэлнэ. Түрсээ шахах үе 7 дугаар сарын дунд үе хүртэл үргэлжилнэ. Энэ загас хаврын үржилтэй учраас энэ үед барихыг хуулиар хориглосон. Элдэв идэш загс жараахай шатандаа хүрд хорхой салаа болон сэлүүр хөлт хавч авгалдайгаар бие гүйцсэн үедээ детрит цахиур болон хөх ногоон замаг усны ургамлаар хооллоно. Мөнгөлөг хэлтэг нь өөрийн амьдарч байгаа усны найрлага дахь хүчилтөрөгчийн хэмжээ багассан үед хошуугаа усны мандалд гарган агаараас хийг сорон авч хүрээлэн байгаа усыг хийжүүлж чаддаг онцлогтой. Хэлтэг усны ёроолын жижиг амьтад, заримдаа ургамал ч иддэг. Монгол улсад мөнгөлөг хэлтэг загасыг Амьтны тухай хуулиар жил бүрийн 04 дүгээр сарын 01-нээс 06 сарын 01 хүртэлх хугацаанд барихыг хориглосон.

Иргэн хуулийн этгээд мөнгөлөг хэлтэг загасыг энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.8. дахь заалтаар жил бүрийн 06 дугаар сарын 16-наас дараа оны 03 дугаар сарын 31 ны өдөр хүртэлх хугацаанд мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1.: 28.4 –д зааснаар нэг удаагийн эрхийн бичгээр иргэнд 3 хоногийн хугацаанд 10 ширхэгээс илүүгүй барьж болно.

Овог – Хулдынхан

Тул – Hucho taimen
Орос нэр – Таймень
Англи – Taimen



Биологи: Одоо Идэр , Чулуут , Орхон гол, Тэрхийн цагаан нуурт амьдардаг. Бие гүйцсэн тул 1,2-1,5 метр , жин 22-45 кг хүрдэг. Лагс бүдүүн биетэй том том амтай нуруу тал боровтор бараан , биеийн хажуу тал улбар шаргал хэвлий нь мөнгөлөг цагаан өнгөтэй сүүлний үзүүр угийн дээд доод сэлүүр улаан өнгөтэй үржлийн үед хэвлийн сэлүүр нь улаан өнгөтэй болдог. Нуруун талд мөн сүүлний сэлүүрийн өмнө өөхөн сэлүүр бий. Бие гүйцсэн тул хулгана, жижиг хөхтөн мэлхий , усны шувуу иддэг. Толгойн дээд толбонууд тодорхой эгнээ үүсэлгүйгээр тархсан байна. Хайрс маш жижиг нягт хажуугийн шугамын дээд хэсэг Х хэлбэртэй хар толботой , дээд доод эрүү ихэнхдээ хүчирхэг шүдтэй. Хүчилтөрөгчөөр баялаг уулын ширүүн урсгалт голын харгиа , цүнхээл , цутгал голын оррчимд амьдарна. Үржлийнхээ үед атуух / эр / загасны сүүлний сэлүүр часулаан биеийн өнгө маш тод гоёмсог болож ирнэ. Тул удаан өсөлттэй 100 хүртэл жил насалдаг гэж тэмдэглэсэн байдаг. Тул 4 дүгээр сарын сүүлч 5-р сарын эхээр усны температур 6-10 хэм болоход хайрга чулууны ёроолд урсгал хэсэгт сүүлээрээ хонхойлж 20-30 см гүн хонхойлж 5,3-58 мм –ийн гүнтэйд дунджаар 14,3 мянган түрс шахна. Мах түрсийг хууль бусаар ашиглах оролдлого гарч болзошгүй. Мөн толгойг нь дэлгэж хатаагаад бэлэг дурсгалын зориултаар худалдаалах магадлалтай. Спорт агнуурын чиглэлээр хайр гамгүй барьснаас болж тархац нутаг нь 60 хувиар багассан. Монгол орны загасны Улаан дансанд бүртгэгдсэн Ховор загас юм. Амьтны тухай хуулийн дагуу Монгол улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоолоор ховор амьтны тоонд оруулсан. Тул загасыг жил бүрийн 10 дугаар сарын 30-наас дараа оны 6 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд барихыг хуулиар хоригложээ. Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээгээр Тул загасыг -211000 төгрөгөөр үнэлээд БОХУБ актаар уг үнэлгээг 2 дахин өсгөн нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

Овог –Гутаарыхан

Гутаарь –Lota lota

Орос нэр – Налим

Англи нэр – Burbot or Freshwater Cod



Биологи: Хангайн нурууны Орхон гол, Сэлэнгэ мөрөн, түүний цутгалуул, Хөвсгөл, Тэрхийн цагаан нуур болон Буйр нуурт, Хэрлэн голд амьдарна. Биеийн зүс хар ногоовтор амьдрах орчны онцлогоос хамааран өнгө нь хувирдаг. Бие уртавтар сүүл хажуугаасаа хавчгар өргөн эрүү дороо гану сахалтай, эрүү самалдагтаа өргөслөг шүдтэй. Гутаарт хэмээх загас нуруу сэрвээндээ хоёр сэлүүртэй эрүү доороо сахалтай. Гонзгой урт биетэй толборхог бараан зүстэй байдаг. Сүүл урт загас юм. Чулуун дор сүүдэрт хорогдож хэвтээд шөнийн цагт идээшлэнэ. Биеийн урт 1 м жин 24 кг хүрнэ. 3 насандаа бэлгэ боловсорч 12 дугаар сарын сүүлчийн хагасаас 2 дугаар сар хүртэл үржилд орж нэг эм атуу ойролцоогоор 20,5-97,8 мянган ширхэг түрс гаргана. Махчин загас, Варлан сахалт эрээлж чимхүүр улаан нүдэн алганаар хооллоно. Дотоод эрхтний 20 хувийг элэг эзэлнэ. Түргэн урсгалт гол мөрөн өндөр газрын жихүүн устай нуурт амьдарна. Гол мөрөн, нуурын хад чулуу элбэгтэй ёроол хэсэгт өдрийн цагт чулуун дор сүүдэрт хорогдож хэвтээд шөнийн цагт идээшлэхээр гөрөөнд гарна. Сүүлийн үеийн эрчимтэй ажиглагдах болсон уур амьсгалын дулаарлаас цутгал голын усны түвшин огцом доошилж загас үржлийнхээ үед голоо өгсөхдөө боогдох хүчилтөрөгчийн дутагдалд орох үржлийн талбай нь усгүй болж ширгэснээс үр тогтсон түрс хагарч амжилтгүй хатаж байна. Ийм учраас орон нутгийн хэмжээнд үржлийнх үед хатаж ширгэсэн газраас загасыг төрөл зүйлийг хамгаалахад бидний оруулах бодит хувь нэмэр болно. Мөн худалдаан б хууль бус агналт хорогдох шалтгаан гэж үзэгджээ. Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээгээр гутаарь загасыг - 13000 төгрөгөөр үнэлээд БОХУБ актаар уг үнэлгээг 2 дахин өсгөн нөхөн төлүүлэх арга хэмжээ авна

Овог – Цурхайныхан

Цурхай – *Esox lucius*

Орос нэр – Амурская щука

Англи нэр – Amur Pike



Биологи: Хангайн нурууны Идэр, Чулуут голын доод хэсэг, Орхон гол, Тэрхийн цагаан нуур, Хэрлэн голд амьдарна. Хаврын сүүлчээр гүехэн булан тохойн наранл хурдан ээгдлэг хэсгээр их тааралдана. Зун цурхай их гүн биш урсгалтай хэсгээр, өвөл тийш шилжин нүүдэлж голын тохойн загас элбэгтэй газарт өвөлжинө. Сэлэнгэ мөрний сав, өгий, Буйр нууранд амьдарна. Цурхайн багт цөөвтөр загас хамаарагдана. Эдгээрээс цурхайн овогийн 2 зүйл загас Монгол оронд бий. Эндердийн цурхай, амарын цурхай гэж 2 ангилна. Биеийн зүс бор ногоовтор, эрээн бие хажуугаар том элгэн хүрэн юмуу хар толбонуудтай заримдаа хөндлөн судал үүсдэг. Сэрвээ ба сүүлний далан дээр бараан толботой. Бие сунаж уртассан сум хэлбэрийн толгой уртавтар доод дээд эрүү тагнай хэлэндээ хүчирхэг шүдтэй хайрс жижигхэн нимгэн биеийн урт 1,5 м жин 35 кг хүрнэ. Урсгал намуун ихтэй хэсгээр зонхилон идээшилдэг махчин загас юм. 3-4 насандаа бэлгэ боловсорч хавар дөнгөж мөс унангуут үржилд орж нэг ам атуу ойролцоогоор 1 сая хүртэл тооны диаметр 3 мм орчмын түрс ургамалд шахаж орхино. Өсвөр насны цурхай хөвөгч амьтан ёроолын шавьжийн авгалдайгаар бие гүйцсэн үедээ загасаар хоолоно. Хавар гол мөрөн нуурын мөстэй байхад ч үржинэ. Өнгөрсөн жилийн ургамлын үлдэгдэл ихтэй эрэг орчмын хэсэгт түрсээ шахна. Мөргийн язгуурын загасыг ихэвчлэн иддэг бөгөөд мэлхий, усанд орж ирсэн хулгана, шувуудыг барьж иднэ. Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээгээр цурхай загасыг -20000 төгрөгөөр үнэлээд БОХУБ актаар уг үнэлгээг 2 дахин өсгөн нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

Овог – Чоныхон

Хярс үнэг – *Vulpes corsac*

Орос нэр – Корсак

Англи нэр – Corsac Fox



Биологи : Хярсны ерөнхий зүс цайвар шаргал хэвлий нь цагаан шаргал өнгөтэй зөөлөн шигүү үстэй , сүүлний үзүүр хар хүрэн өнгөтэй байна. Ерөнхийдөө үнэгтэй төстэй боловч арай жижгэвтэр ойролцоогоор 30см өндөр 50-60 см урт байна. Ойт хээр хээржүү уулын хаяа энгэр довцог толгод харгана бут сөөг бүхий нутгаар гүйдэлтэй. Тарвага , зурам зэргийн амьтдын орхисон нүхийг засаж байрладаг. Заримда нүх малтана. Үдшийн бүрэнхий шөнийн цагаар идэвхтэй байна. Хярс үнэрч сонсгол сайтай амьтан . Ихэвчлэн оготно , огодой бусад жижиг мэрэгчээр хооллоно. Хярс амьдралынхаа туршид хосоороо амьдарна. Өвөл ороо хөөцөлдөө нь явагдаж эмэгчин хярс 50-60 хоног хээлээ тээгээд 5 дугаар сард нүдээ нээгээгүй 2-11 гөлөг төрүүлнэ. Гөлөг нь 14-16 цагийн дараа нүдээ нээж нэг сар болоод амьтны гаралтай тэжээл хэрэглэж эхлэнэ. 3 дугаар сарын сүүлчээр гуужиж тачирхан богино үсэн бүрхүүлтэй зусаад намар соржиж өтгөн ноолууртай болно. Хараа хяналтгүй агнуур ховордуулах гол шалтгаан болсон. Хярс үнэгний тархац нутгийг 12 хувийг улсын тусгай хамгаалалтанд авагдсан байна. БОНХ-сайдын 2014 оны А- 61 тоот тушаалаар хярс үнэгийг 2014 оны 02 дүгээр сарын 25-ны өдрөөс дахин 3 жилийн хугацаагаар нийт нутгаар агнахыг хориглосон. Мөн жил бүрийн 2 сарын 11 нээс 11 сарын 20 хүртэлх хугацаанд агнахыг Амьтны тухай хуулиар хоригложээ.

Нутгийн нэр – Цагаан бураа, шар бургас

Төвд нэр – Жанмаа , жан-гар-бо , дагва

Орос нэр – Ива каспийская

Латин нэр – *Salix Ledebouriana*
Англи нэр – *Ledebourian s Willow*



Тархац : Хөвсгөл , Хэнтий , Хангай, Монгол Дагуур , Ховд ,Монгол Алтай , Их нууруудын хотгор , Олон нуур , Дорнод Говь, Говь Алтай, зүүн гар , Алтайн өвөр нутгийн гол горхины эрэг, хөндий элс, хайрга , сайр , нугад ургана.

Таних шинж : Лебебурын бургас цайвар бор холтостой . Навчис бүтэн захтай үзүүрээдээ жижиг шүдлэг , хоёр тал нь нэгэн жигд хөх саарал навчны дагаваргүй. Найлзуур хөхөмдөг саарал юмуу цагаан шарга. Мөчир салаа нь цагаан лаван өнгөтэй. Цэцэглэх нахиа навчлах нахианаасаа онц ялгагдахгүй . 2-5 м хүртэл өндөр саглагар мөчирлөг сөөг. Голын хөндий шугуй үүсгэдэг сөөг бол бургас юм. Бургас саланги бэлэгтэй , цэцэгт эр, эм ургамал. Баянмөнх суманд Баянбулаг, Хэрлэн , Дулаан багийн нутгаар 808 га газрыг хамарсан бургасан ойтой, ой бүхий сумын нэг юм. Ховордсон шалтгаан Хууль бус мод бэлтгэл, ойн түймэр, удаан үргэлжилсэн хуурайшилт зэргээс шалтгаалан эрс хомсдолд орж болзошгүй . Байгалийн ургамал , ойн дагалт нөөц баялгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээгээр тодорхой хугацаанд тухайн зориулалтаар тогтоосон хяналтын дор ашиглаж болно.

Овог – Минжийхэн
Голын минж – *Castor fiber*

Орос нэр – Бобр
Англи нэр – Beaver



Биологи : Манай орны мэрэгчдийн доироос хамгийн том биетэй үнэт үслэг нэн ховор дархан цаазтай ан амьтан . Ховд аймгийн Булган , Ховд голд тархсан. Биеийн урт 75-120 см жин 18-25 кг усанд сэлж явахад зохилдож хойд мөчдийн хурууд сарьсаар холбогдсон , сүүл өргөн хавтгай хайрсаар хучигдсан байдаг. Ороо нийллэг 1-2 дугаар сард болж 105-107 хоногийн дараа 2-4 зулзага гаргана. Гурван насандаа бэлгэ боловсорч үржилд ордог. Улиас , бургас элбэгтэй зөөлөн урсгалт голын эрэг булан тохой , тогтуун устай эргэнд нүх ухаж бургас улиасаар овоохой барьж орогноно. Овоохойд орох нүхний амсар усанд дотор байна. Модон овоохой янз бүр байх боловч зонхилон 1-3 м , диаметр нь 10 орчим метр байх ба голын эрэгт нүх малтаж эгц доошоо цоолж агаар агаар оруулах нүх гаргасан байна. Голын усны түвшин нэмэгдэх үед овоохойгоо урсахаас хамгаалан далан барьдаг. Мод мэрэн унагаахад зонхилдсон хурц шүдээрээ 5-7 см диаметр модыг 2 минутад тойруулан мэрж унагадаг онцлогтой. Хэрлэн голд минж дулаан багийн нутагт нутагшин амьдрах болсон . Ховордож устахын даваан дээр байсан голын минжийг агнахыг бүр мөсөн хориглож нутагшуулан үржүүлж байна. Монгол орны хөхтөн амьтны Улаан дансанд болон Амьтны тухай хуулинд 2012 онд нэн ховор зүйл зэрэглэлээр бүртэгджээ. Голын минжийн тархац нутгийн 11 орчим хувь нь улсын тусгай хамгаалалттай газарт хамрагдаад байна. Засгийн газрын 2011 оны 23 тоот тогтоолоор баталсан ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээгээр Борхинг – 1300000 , Минжүүхэйг – 1500000 , Эр дүдэрийг 910000 , Эм дүдэрийг 1050000 төгрөгөөр тус тус үнэлээд БОХУБ актаар уг үнэлгээг 2 дахин өсгөн нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.Зөвхөн эрдэм шинжилгээний зориулалтаар нэг толгой минж- 260000 төгрөгийг орон нутгийн дансанд урьдчилан тушаасан байна.

Овог – Туулайтан
Бор туулай – *Lepus torai*
Орос нэр – зайцетолай
Англи нэр - Tolai Hare



Биологи: Биеийн урт 45-65 см, жин 1,5-2,6 кг зэгэл саарал зүстэй чихний үзүүр , сүүлний дээд хэсэгт хар өнгөтэй байдаг. Манай нутагт жигд тархсан . Тариалангийн талбай , хангана дэрс бүхий дор газар амьдардаг. Өвслөг болон модлог ургамлын мөчрөөр хооллоно. Эрдэмтдийн судалгаагаар туулай 40 орчим зүйлийн өвслөг бутлаг ургамал иддэг байна. Жилд 1-2 удаа үрждэг . Эмэгчин туулай 35-48 өдөр хээлээ тээж 65-954 гр жинтэй бүжин гаргана. Өглөө оройн цагаар идэвхтэй бэлчээрлэнэ. 4-6 лугаар сар, 9-10 дугаар сард гуужина. Туулайн гол дайсан нь үнэг , хярс, чоно, шилүүс бүргэд мөн хүн зэрэг болно. Бор туулай хэдэн төрөл зүйлтэй байдаг ба ногоон бүсэд хаяа түвд туулай тааралдана. Түвд бор туулай биеийн ерөнхий байдал туулайтай ижил биеийн урт нь 39-53 см өнгө зүс бор саарлаас улаан боровтор. Модны хормой орчмоор бут сөөг бүхий газар уулын жалга сайрт тохиолдоно. Өвслөг ургамлаар хооллоно. Бор туулай маш сэргэг , аймхай амьтан. Түүний хэвтэр байрлаж байгаа орчинд ямар нэгэн амьтан ойртож байгааг алсаас мэдэж тэр даруйдаа гэнэт үсрэн хол хол дэгдэн дүүлж зугатдаг онцлогтой. Уламжлалт анагаах ухаанд хэрэглэх үүднээс агнадаг олон улсын худалдаа бага, хааяа үнэг хярсанд тавьсан хавх урхинд өртөх нь бий.

5. ТҮҮХИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Баянмөнх сумын ТСҮХөдлөх дурсгалууд

1. Адуун хориотын хиргисүүр

Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 20 гаруй км-т, Язаар уулын салбар Адуун хориот хэмээх уулын баруун хойд дор нь 3 хиргисүүр байна. Хиргисүүрүүд нь бүгд хүрээ болон дагалдах байгууламжгүй юм.



2. Авдар хад орчмын дурсгалууд:

Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс зүүн зүгт 20 км-т, Баянцогт уулын хойд талд, Хэрлэн голын урд эрэг дээр Авдар хад хэмээх дөрвөлжин хад бүхий уул бий. Энэ уулын урд дэвсэг болон урд, зүүн энгэрээр нийт 20 дөрвөлжин булш, 20 хүннү булш, 3 тахилын онгон байна. Мөн эндээс неолитын үеийн чулуун зэвсгийн зүйлс хусуур, ялтас зэрэг цөөн тоогоор олдож байлаа.

- Авдар хад орчмын дөрвөлжин булш:

Авдар хадны дөрвөлжин булшнууд нь 2-10 хүртэлх тоогоороо уулын энгэрээр бүлэглэн орших аж. Булшнуудыг байгалийн бахим чулуудаар хашлага хийн буланд нь хашлаганаас үл ялиг өндөр чулууг суулгаж дотор нь чулуугаар дараас хийн үйлджээ. Булшны дараас чулууд нь газрын хөрстэй тэнцүү шахуу болжээ. Булшнуудын гадаад хэлбэр зохион байгуулалт нь ижил боловч хэмжээний хувьд харилцан адилгүй байлаа. Дөрвөлжин булшнуудын анхны зохион байгуулалт малын хөл болон бусад хүчин зүйлээс шалтгаалан нилээд алдагдсан байна.



- **Авдар хад орчмын хүннү булш:**

Авдар хадны урд талын тэгш дэвсэг дээр, дэрсэн дунд 20 орчим дугуй булш байна. Булшнууд нь дугуй чулуун далантай голдоо үл ялиг хонхортой мэт юм. Эдгээр дурсгалууд нь Хүннү жирийн иргэдийн булш бололтой юм.

- **Авдар хад орчмын тахилын онгон**

Авдар хадны урд орших Хүннүгийн бүлэг булшнаас зүүн зүгт 200 орчим метрийн зайд 3 тахилын онгон байна. Тахилын онгоныг байгалийн хавтгай чулууг хайрцаглан дотор нь чулуу дүүргэж үйлдсэн байх аж. Дурсгалууд нь хойноос урагш чиглэлтэй байрласан байна.

3. **Агуйт уулын дурсгалууд:**

Агуйт уулын уулын урд талын ханан хадны хормойд чулуугаар өрж хаалга гаргасан жижиг агуй байдаг.

- **Агуй:** Агуйн үүдэн талын өндөр тавцан дээр бурхан шашны холбогдолтой эд өлгийн зүйлс /баринтагтай ном, жижиг бурхан, төгрөг, арц хүж/ байна. Нутгийнхны өгүүлж буйгаар бол энд дээр үеийн лам нар ирж даяанчилж суудаг байжээ. 1990-ээд он хүртэл агуйн үүдний тавцан дээрх бурхан шашны холбогдолтой эд зүйлс байсан боловч түүнээс хойш олз хайгсад ирж авч одох нь элбэг болсон байна.

- **Агуйт уулын хиргисүүр:**

Баянмөнх сумын Баянбулаг багийн нутаг, сумын төвөөс урд зүгт 30-аад км-т, Язаар уулын салбар Агуйт гэх хана хадтай уул бий. Энэ уулаас зүүн урагш 1 км гаруйд, Агуйтын булгийн зүүн хойд талд 1 хиргисүүр байна. Хиргисүүр нь дугуй хүрээтэй, 10 орчим дагалдах байгууламжтай юм.



4. Алтан өлгий уулын дурсгал:

Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 30-д км-т, Язаар уулын салбар, уулын баруун урд хэсэгт Алтан өлгий гэх уул бий. Энэ уулын энгэр бэлээр 4 хиргисүүр, 5 дөрвөлжин булш байна.

- **Алтан өлгий уулын хиргисүүр:** Энд байх хиргисүүрүүдийн голын дараас нь эрт эдүгээ үед хүн малын гар хөлөөр ихэд таржээ.

Хиргисүүр-1: Алтан өлгий уулын урд энгэрт байна. Дугуй хүрээтэй, 20 дагуул тахилын байгууламжтай.

Хиргисүүр-2: Уулын ар дор нь байна. Дугуй хүрээтэй, 7 дагалдах байгууламжтай.

Хиргисүүр-3: Дээрх хиргисүүрээс баруун хойно 200 метрийн зайд Айлын саравчны урд талд байна. Дугуй хүрээтэй 17 дагалдах байгууламжтай.

Хиргисүүр-4: Дээрх дурсгалуудын хамгийн хойд захад Язаарын дээд үзүүрийн энгэрт айлын саравчны хойд талд оршино.



- **Алтан өлгий уулын дөрвөлжин булш:** Язаарын Алтан Өлгий уулын хиргисүүрүүдийн хажууд нийт 5 дөрвөлжин булш байна. Хиргисүүр-1, Хиргисүүр-3 ийн хажууд тус тус 2,3 аараа оршино. Булшнуудын анхны зохион байгуулалт нь бага

зэрэг алдагдсан байлаа. Байгалийн энгийн чулуугаар дөрвөлжин далан үүсгэж дээрх дөрвөлжин булшнуудын үйлдсэн аж.

5. Баянбулагийн дурсгал: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт сумын төвөөс урд зүгт 20 орчим км-т, Баянбулаг булгийн эхэнд булгийн зүүн дэнж дээр 2 хиргисүүр, 7 дөрвөлжин булш байна. Энд орших дурсгалууд нь анхны хэлбэр зохион байгуулалтаа бүрэн алдсан байлаа.

- **Баянбулагийн хиргисүүр:** Баянбулгийн зүүн дэнж дээрх 2 хиргисүүрүүд дугуй хүрээтэй, дагалдах байгууламжгүй юм.



- **Баянбулагийн дөрвөлжин булш:** Баян булгийн зүүн дэнж дээр нийт 7 дөрвөлжин булш байна. Хамгийн баруун захад орших хиргисүүрийн дугуй хүрээн дотор 4, хүрээний гадна талд 1 дөрвөлжин булш байгаа бол зүүн талд байх хиргисүүрийн баруун хажууд 2 дөрвөлжин булш байх аж. Дөрвөлжин булшнуудыг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн дэвсэж үйлджээ. Дурсгалуудын анхны хэлбэр малын хөлд дарагдан эвдэгдсэн байлаа.



6. Баруун дөрвөлжин уулын дөрвөлжин булш: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт сумын төвөөс 30 орчим км-т, Язаар уулын салбар уул болох Баруун дөрвөлжин хэмээх уулын энгэрт 2 дөрвөлжин булш байна. Баруун дөрвөлжин уул нь Солби уулын хойд талд орших аж. Дөрвөлжин булшийг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн далан үүсгэж үйлдсэн байна.



7. Баянцагаан уулын дурсгал: Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс зүүн урд зүгт 20 орчим км-т Хүнхэр хэмээх талын баруун хойд талд байх намхавтар уулыг Баянцагаан хэмээн нэрийдэх аж. Энэ уул орчмоор нутгийнханы эртнээс тахиж ирсэн тахилгат овоо, уулын энгэрээр 10 орчим дөрвөлжин булш, уулын баруун дор 1 хиргисүүр, уулын зүүн хойд талд 11 дугуй булш, хадны зураг, хүн чулуун хөшөө гэх дурсгалууд байна.

- **Баянцагаан уулын тахилгат овоо:** Баянцагаан уулын орой дээр байх бөгөөд чулуу өрж босгосон аж.

- **Баянцагаан талын хүн чулуун хөшөө:** Баянцагааны талд Баянцагаан уулын баруун урд, багийн төвийн баруун талд 500 метрт нэгэн хэвтээ хүн чулуун хөшөө бий. Хүн чулуун хөшөөний зүүн талд худаг байна. Хөшөөг саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн бөгөөд эдүгээ хөлийн хэсгээрээ хугарч унасан байдалтай байна. Хөшөөний толгой талд хүний нүүрийг гаргаж хүн, хамар, сахал, ам, эрүүний хэсгийг дүрсэлсэн байна. Хөшөөний нүүрний дүрслэгдэхүүн н хүний нүүрний тэгийг нэлээд алдагдуулан дүрсэлсэн байлаа. Хөшөөнд хүний нүүрнээс өөр дүрслэл байхгүй байна. Хөшөөний хүний нүүрнээс өөр дүрслэл байхгүй байна.



- **Баянцагаан уулын энгэрийн дөрвөлжин булш:** Баянцагаан уулын өвөр бэлээр 10 орчим булш бий. Энд анхны хэлбэр зохион байгуулалтаа бүрэн алдсан дөрвөлжин дугуй хэлбэрийн булш байна. Булшнуудад тодорхойлолт бичих болон хэмжилт хийх боломжгүй болсон байв.
- **Баянцагааны талын тамга тэмдгийн дүрслэл:** Баянцагаан уулын баруун хойд тал Баянцагааны талд орших хиргисүүрээс зүүн тийш 534 метрийн зайд том ургаа хаднууд бий. Эдгээр хаднуудын баруун хойд талын хадан дээр нэгэн тамганы дүрслэл сийлсэн байна.



- **Баянцагаан уулын хүннү булш:** Баянцагаан уулын зүүн хойд талын дэвсэг дээр 11 хүннү жирийн иргэдийн бололтой дугуй чулуун далантай, голдоо ялимгүй хонхойсон булш байна.



- **Баянцагааны талын хиргисүүр:** Баянцагаан уулын баруун талын хэсгийн Баянцагааны тал хэмээн нэрлэх бөгөөд энэ талд, уулын баруун хойд талд хүрээ, дагуул байгууламжгүй 1 хиргисүүр байна.



8. **Баянцогтын дурсгал:** Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс зүүн зүгт 20 км-т, Хэрлэн голын урд биед Баянцогтын хэмээх уул оршино. Нутгийнхан Баянцогтын булан ч гэх нь бий. Энэ уулын урд энгэрт, хормойд, зүүн биеэр 1 хиргисүүр, 60 орчим дөрвөлжин булш, 12 тахилын онгон оршино.

- **Баянцогтын чулуун зэвсгийн дурсгал:** Мөн уулын урдуур болон уулын араар неолитын үед хамаарах олон тооны чулуун зэвсгийн зүйл таарч байлаа.
- **Баянцогтын хиргисүүр:** Баянцогтын хиргисүүр нь уулаас урагш 900 метрийн зайд дэрсэн дунд оршино. Хигисүүрийн хүрээ дагалдах байгууламж мэдэгдэхгүй, дараас чулуу нь тарсан байлаа.
- **Баянцогтын тахилын онгон:** Баянцогт уулын зүүн талд 2 хэсэг газар нийт 12 тахилын онгон байна. Эхний хэсэгт 5 тахилын онгон 2 дахь хэсэгт 7 тахилын онгон байлаа. Байгалийн нимгэн чулууг хайрцаглан дотор нь чулуу дүүргэж үйлдсэн дээрх дурсгалуудын хажууд хөшөө болон зэл чулуу байхгүй байна.



- **Баянцогтын зэл чулуу:** Баянцогт хэмээх уулын урд баруунаас зүүн тийш зэллэсэн 12ш чулуу байна. Ойролцоо тахилын байгууламж алга юм.

- **Баянцогтын дөрвөлжин булш:** Баянцогтын буланд 60 орчим дөрвөлжин булш байна. Булшнууд нь 5-7-оороо бүлэглэн өөр хоорондоо нилээд зайтай байрлана. Булшнуудын гадаад хэлбэр зохион байгуулалт нь ижил боловч хэмжээний хувьд харилцан адилгүй байлаа. Зарим томоохон булшнуудын буланд хашлаганаас өндөр хөшөө гэхээр чулууг суулгасан байв. Булшны ханыг байгалийн энгийн чулууг ашиглан хайрцаглаж суулгаад дотор талыг чулуугаар даржээ. Зарим булш нь тоногдсон, зарим булшинд малтлага хийсэн бололтой байна.

9. Баянмөнхийн хийдийн туурь: Баянмөнх сумын Хэрлэн багийн нутагт сумын төвөөс зүүн хойд зүгт 20 гаруй км-т, Хэрлэн голын хойд биед нутгийнханы тахин шүтдэг Баянмөнх хэмээх уулын баруун урд талын аманд 1 барилгын суурь байна. Үүнийг нутгийнхан Баянмөнхийн хийдийн туурь байсан хэмээдэг. Энэ дурсгалын хажууд Дацангийн худаг хэмээх булаг байна. Хийдийн туурь орчмоос сүм хийд байсныг гэрчилэх эд зүйлс бараг олдоогүй. Дурсгалыг гадаад байдал нь чулуун далан мэт ажээ.



10. Бүрдийн дацангийн туурь: Баянмөнх сумын Хэрлэн багийн нутагт сумын төвөөс баруун хойд зүгт 40-өөд км-т, Хэрлэн голын хойд хөндийд, Бүрдийн Дацангийн туурь оршино. Энэхүү дурсгалын баруун хойд талд нь Дэлгэрхаан сумын Хэрлэн тооно уул харагдаж байна. Эдүгээ тус хийдийн туурины орчим барилгын бололтой хэдэн суурь л үлджээ. Эндээс барилгын тоосго, дээврийн ваарны жижиг хэсэг зэрэг зүйлс олдож байв.

11. Гурван овоотын агуй: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутаг дахь сумын төвөөс урагш 20 гаруй км-ын зайд орших Язаар уулын салбар Гурван овоот хэмээх уулын баруун хойд талд баруун хойшоо харсан амсартай нэгэн агуй байна. Энэ агуйд лам нар бясалгаж байсан хэмээн нутгийнхан хэлж байлаа. Энэ агуй дотор хүний дунд чөмөгний яс, шашны эд зүйлс, гавлын яс гэх эд зүйлс олдож байв. Агуйн доторх зарим эд зүйлсийг олз хайгчид авч явжээ.



12. Доод улаан эргийн үйлдвэрлэлийн ул мөр бүхий дурсгал: Баянмөнх сумын төвийн, зүүн, баруун талд байх Хэрлэн гол руу шахсан эрэг, мөргөцөгийг нутгийнхан “Улаан эрэг” хэмээн нэрлэдэг аж. Сумын төвөөс зүүн тийш Хэрлэн голын урд талд уртрагын дагуу 2 км орчим сунаж тогтсон улаан шаварлаг хөрс бүхий эргийн дагууд бороо, үерийн усанд ихэд идэгдсэн хоорондоо зайтай олон гуу жалга буй. Нутгийнхан ходоодонд сайн хэмээн эртнээс ундаалж ирсэн “Эргийн рашаан” хэмээх булгаас баруун тийш 300 орчим метр зайтай жалганд галд шатсан хөрсний үе, ваар савны хагархай зэрэг зүйлс ихээр тархсан байв. Шатсан хөрсөнд ваарны хагархай ихтэй ба хатуурч шатсан шаварлаг хөрс байгааг зуухны үлдэгдэл хэмээн үзэж болмоор ажээ. Энэхүү жалга нь голоороо усанд идэгдэн эвдэрч нурсан ба жалганы дээд хэсгийн хоёр талаар нилэнхүйдээ шатсан хөрсөн үе болон ваар савны хагархай үлдэгдлүүд ихээр тархсан байгаа нь эрт үед энд үйлдвэрлэлийн газар байсныг гэрчилэх баримт хэмээн үзэж болохоор юм.

13. Дулаан уулын дурсгал: Баянмөнх сумын Дулаан багийн нутагт сумын төвөөс зүүн урагш 28 км-т, Дулаан хэмээх урт уулын энгэр бэлээр болон уулын оройгоор, уулын ард нийт 10 гаруй хиргисүүр, 100 орчим дөрвөлжин булш, 30 орчим хүннү булш, 8 тахилын онгон, 1 хөшөө чулуу, 20 орчим монгол булш, 3 хадны оршуулга байна. Энд БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай “Их Мянганы үүд” ХХК-ны ашиглалтын талбай байдаг бөгөөд энэхүү уурхай нь үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнээр энд орших олон дурсгалууд устаж үгүй болох магадлалтай байх аж.

- **Дулаан уулын хиргисүүр:** Дулаан уулын урд энгэрээр нийт 10 гаруй хиргисүүр байна. Хиргисүүрүүдийн ихэнх нь анхны төрхөө алдсан байсан бөгөөд зарим хиргисүүр нь дугуй хүрээтэй 15 хүртэл тооны дагалдах байгууламжтай бол зарим нь хүрээ болон дагалдах байгууламжгүй хиргисүүрүүд байлаа. Хиргисүүрүүд уулын урд хормойд зүүнээс баруун хүртэл өөр хоорондоо 50-500 хүртэлх метрийн зайтай оршино.



- **Дулаан уулын Хүннү булш:** Дулаан уулын Баруун богино хэмээх уулын зүүн урд байх уулын онины урд 1 хүннү булш байна. Булш нь дугуй чулуун хүрээтэй голдоо үл ялиг хонхортой юм. Мөн Баруун богино уулын урд энгэрт уурхайн ухсан 2 нүхний хажууд 30 орчим дугуй хүрээтэй булш байна. Ихэнх булш эвдэгдсэн байлаа.
- **Дулаан уулын хөшөө чулуу:** Дулаан уулын баруун урд хормойд 6 тал бүхий нэгэн хөшөө чулуу бий. Хөшөөг саарал өнгийн хайрган чулуугаар үйлдсэн байх бөгөөд гадаргуу дээр нь ямар нэг тамга тэмдэг хийгээр бичиг үсгийн дүрслэл байхгүй юм. Хөшөөний дэргэд уг чулуутай ижил хар саарал өнгийн урт чулуу сул хэвтэнэ.



- **Дулаан уулын хадны оршуулга:** Дулаан уулын Өлийн бууц хэмээх газрын баруун талд зүүн урагш харсан эгц ханан хад бий. Энэхүү Ханан хад нь Өлийн бууцнаас чанх баруун тийш 500 метрт оршино. Ханан хадны ероолд хадны хөмөг ашиглан үйлдсэн 3 хадны оршуулга байна. Дээрх дурсгалууд нь өөр хоорондоо 26-200 метрийн зайтай орших бөгөөд голын дурсгал хөндөгдсөн бололтой байна.
- **Дулаан уулын тахилын онгон:** Дулаан уулын зүүн хойд ард 2 хэсэг газарт 4,4-рөө нийт 8 тахилын онгон байна. Тахилын онгоныг байгалийн нимгэн хавтгай чулуугаар

хашлага хийж дотор нь чулуу дүүргэж үйлдсэн аж. Харин хөшөө болон зэл чулуу байхгүй байлаа. Хоёр бүлэг тахилын онгоны баруун талын 4 дурсгалын 1-ыг ухаад буцаж булсан байна. Нутгийн иргэд мэргэжлийн байгууллага ирж малтаагүй хэмээж байлаа.

- **Дулаан уулын Монгол булш:** Дулаан уулын энгэрээр мөн салбар намхан толгодын дээд энгэрээр 20 гаруй монгол булш байна. Булшнууд нь үл ялиг зууван хэлбэртэй чулуун дараастай байх аж.
- **Дулаан уулын дөрвөлжин булш:** Дулаан ууланд нийт 100 орчим дөрвөлжин булш байна. Эдгээр дурсгалуудыг уулын ар, уулын энгэрийн хэмээн 2 хуваан бүртгэв.

Дулаан уулын баруун хойд дор болон уулын чанх хойд талын намхан толгод дээр нийт 6 дөрвөлжин булш байна. Булшнуудыг байгалийн энгийн чулуугаар хашлага хийн дотор нь чулуугаар дүүргэж үйлдсэн нийтлэг зохион байгуулалттай байлаа.

- **Дулаан уулын энгэрийн дөрвөлжин булш:**

Дулаан уулын энгэр бэлээр нийт 90 гаруй дөрвөлжин булш оршин байна. Булшнуудын зарим нь уулын урд хормойн хиргисүүрүүдийн хажуугаар байх бол зарим булш уулын хөтөл, уулын энгэрээр голдуу байлаа. Булшнуудыг байгалийн энгийн чулууг ашиглан дөрвөлжин далан үүсгэж үйлдсэн, чулуугаар хашлага хийж дотор нь чулуугаар дараас хийсэн, байгалийн чулууг дөрвөлжлөн дэвсэж үйлдсэн гэх мэтээр олон төрлөөр үйлдсэн байв. Гэвч дээрх дурсгалуудын ихэнх нь энд үйл ажиллагаа явуулж буй уурхайн том даацын машины нөлөөгөөр бүрэн эвдэгдсэн байлаа. Мөн зарим булшнуудыг тоносон байна. Бид дээрх дурсгалуудыг бүлэглэн буйгаар байршилыг нь тогтоон солбилцолыг авсан болно.

14. Дэлгэрцогт уулын чулуун зэвсгийн дурсгал: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт сумын төвөөс урагш 30 гаруй км-т Язаар уулын урд хэсэгт Дэлгэрцогт хэмээх уул бий. Энэ уулын энгэр орчмоор неолитын үеийн ногоон хүрэн, цагаан өнгийн хас чулууд элбэг олдож байв. Чулуун зэвсгийн зүйлсээс хусуурын төрлийн хас чулууд голлоно. Мөн энэ уулын урд 2 агуй байна.

- **Дэлгэрцогт уулын агуй:** Дэлгэрцогт уулын урд энгэрт зэрэгцээ 2 агуй оршино.

Агуй-1: Баруун талд нь байна амсар нь зүүн урагш харсан. Дотроо уужуу зайтай энэ агуйн амсараар зосон зураг 6-7 байх агаад дүрслэл нь маш ихээр балартсан байна. Амьтны дүрслэл голдуу байлаа.

Агуй-2: Зүүн талд нь байна. Агуй амсар баруун урагш харсан бөгөөд хананд дүрслэл байхгүй, хадны хөмөг шинжтэй байлаа.

15. Дээд улаан эргийн булш: Баянмөнх сумын төвөөс баруун зүгт 3 км орчимд, Хэрлэн голын урд хөвөөнөө Дээд уулаан эрэг хэмээх газар 8 анхны хэлбэр төрхөө бүхэн алдсан дөрвөлжин бололтой булш байна. Эдгээр булшинд тодорхойлолт бичих боломжгүй байлаа.

16. Зүүн талын усны хөшөө чулуу: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс баруун урагш 30 гаруй км-т, Зүүн талын ус хэмээх газарт 1 хөшөө чулуу байна. Энэхүү хөшөө чулуу нь Бор-Өндөр Баянмөнх сумын хоорондох автозамын баруун талд

дэрсэн дунд хэвтээгээр байсныг бид газарт суулган босгосон. Хөшөөг саарал өнгийн хайрган чулууг нимгэн засаж гонзгой дөрвөлжин хэлбэртэй болгосон байна. Хөшөөний ойр орчим дурсгал байхгүй хөшөөн дээр дүрслэл үгүй юм. Хөшөөний тал хэсэг нь хугарсан байлаа.



17. Ичээт уулын дурсгал: Баянхутаг сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 20 орчим км-т Язаар уулын бас нэгэн салбар уул болох Ичээт гэх багавтар уул бий. Ичээт уулын баруун болон хойд талд нийт 3 хиргисүүр, 2 дөрвөлжин булш байна.

- **Ичээт уулын хиргисүүр:** Хиргисүүр-1: Ичээт уулын баруун хормойд байна. Хиргисүүрийн хажууд 2 дөрвөлжин булш байх аж.
Хиргисүүр-2: Ичээт уулын ард байна. Хүрээгүй, 3-5 дагалдах байгууламжтай юм.
Хиргисүүр-3: Ичээт уулын хойд талд байна. Дугуй хүрээтэй, 6 дагалдах байгууламжтай.
- **Ичээт уулын дөрвөлжин булш:** Язаарын Ичээт уулын хиргисүүр-1 ийн хажууд 2 дөрвөлжин булш байна. Булшнуудыг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн дэвсэж үйлджээ.

18. Их ханангийн зүүн хажуугийн шивээ: Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс урагш 30 км-т, Их Салхит уулын урд талд байх Их Ханан хэмээх уулын зүүн хажуугийн жижиг толгод дээр нэгэн шивээ байна. Шивээг байгалийн чулууг овоолон үйлджээ. Шивээний дотор хэд хэдэн газар хонхор үүссэн байлаа.



19. Их цагаан усны хөшөө чулуу: Баянхутаг сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс зүүн урд зүгт 30 гаруй км-т, Их цагаан усны хөндий хэмээх газар 3 босоо 2 унасан, 1 хазайсан хөшөө чулууд байна. Хөшөөдийг хар саарал өнгийн хайрган чулуугаар үйлдсэн байх бөгөөд аль ч хөшөөний гадаргуу дээр ямар нэг тамга тэмдэг болон, дүрс бичгийн дурсгал байхгүй байна.



20. Мандалын хийдийн туурь: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 32 км-т, Дэлгэрцогт уулын урд, хуучин сумын туурийн хажууд Мандалын хийд байсан хэмээн нутгийнхан ярьж байлаа. Энэ газраас барилга байгууламж байсан гэдгийг гэрчилэх туурь, эд зүйл олдсонгүй.

21. Могойн хар өндөрийн дурсгал: Баянхутаг сумын Дулаан багийн нутагт, Холбоо уулын урд, сумын төвөөс урагш 30 км-т, Могойн хар өндөр уул оршино. Энэ уулын орчмоор нийт 6 хиргисүүр, 4 дөрвөлжин булш байна.

- **Могойн хар өндөрийн хиргисүүр:** Энд орших хиргисүүрүүдийн зарим нь дугуй хүрээтэй 30 хүртэл дагалдах байгууламжтай бол зарим нь хүрээ болон дагалдах байгууламжгүй юм. 3 хиргисүүр нь уулын зүүн талд, 2 хиргисүүр нь уулын баруун

талд, 1 хиргисүүр нь уулын ард оршино. Зарим хиргисүүрийн голын дараасыг ухаж үзсэн бололтой байна.



- **Могойн хар өндөрийн дөрвөлжин булш:** Могой хар өндөр уул орчимын хиргисүүрүүдийн хажууд нийт 4 дөрвөлжин булш байна. Булшнууд нь уулын зүүн биед байх хиргисүүрийн хажууд байна. Булшийг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн дэвсэж үйлджээ.

22. Салхит уулын дурсгал: Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс урд зүгт 24 км-т, Их Салхит, Бага Салхит хэмээх хойноос урагш сунаж тогтсон 2 уул бий. Хойд талд орших уулыг Бага Салхит гэх хэмээн нэрлэх ба энэхүү уулын зүүн хажууд 4 хиргисүүр, 7 дөрвөлжин булш байна.

- **Салхит уулын хиргисүүр:** Хиргисүүр-1: дугуй хүрээтэй, 7 дагалдах байгууламжтай. Дурсгалын баруун талд 1 дөрвөлжин булш байна. Хиргисүүр-2: хүрээ болон дагалдах байгууламжгүй. Энэхүү хиргисүүрийн урд талд 1, баруун урд талд 2 дөрвөлжин булш байна.

Хиргисүүр-3: Дугуй хүрээтэй, 25 дагалдах байгууламжтай. Хиргисүүрийн баруун талд 2, зүүн талд 1 дөрвөлжин булш байх аж.

Хиргисүүр-4: дугуй хүрээтэй, 45 дагалдах байгууламжтай. Дагалдах байгууламж нь жижиг цагираг хэлбэртэй болон бөөнөөрөө хагас саран хэлбэртэй байлаа.

- **Салхитын дөрвөлжин булш:** Бага Салхит уулын хиргисүүрүүдийн хажууд нийт 7 дөрвөлжин булш байна. Булшнуудыг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн хана үүсгэж дотор нь чулуугаар дараас хийж үйлдсэн байна. Зарим булшны буланд хашлага чулуунаас үл ялиг өндөр чулууг босгосон байлаа. Бага Салхитын булшнууд нь хиргисүүр-1 ийн баруун урд, Хиргисүүр-2 ийн урд талд 1, баруун урд талд 2, хиргисүүр-3 ийн баруун талд 2, зүүн талд 1 дөрвөлжин булш байх аж.

23. Солби уулын дурсгал: Баянхутаг сумын Баянбулаг багийн нутагт, Язаар уулын баруун хэсэгт байх Солби хэмээх уулын баруун урд энгэрт 2 хиргисүүр, 1 дөрвөлжин булш байна.

- **Солби уулын хиргисүүр:** Энд орших 2 хиргисүүр нь дугуй хүрээтэй, 2-лаа тоногдсон дагалдах байгууламжгүй байлаа.
- **Солби уулын дөрвөлжин булш:** Солби уулын баруун урд энгэрт 1 дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшийг байгалийн энгийн чулуугаар далан үүсгэж үйлджээ.

24. Ханангийн энгэрийн дурсгал: Баянмөнх сумын Хэрлэн багийн нутагт, сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км-т, Хэрлэн голын хойно, Ханан хэмээх урт уул бий. Энэ уулын урд энгэрт 2 хиргисүүр, 15 дөрвөлжин булш, 4 хүннү булш, 2 төвд бичгийн дурсгал байна.

- **Ханангийн энгэрийн хиргисүүр:** Ханангийн энгэрийн гэр бууцны хажууд 1 дугуй хүрээтэй хиргисүүр, түүнээс урагш 100 орчим метрт 1 дугуй хүрээтэй хиргисүүр энд нийт 2 хиргисүүр байна. Хиргисүүрүүдийн дараас мал амьтны хөлөөр нилээд тарамдсан байлаа.
- **Ханангийн энгэрийн хүннү булш:** Зосоор бичсэн төвд бичигтэй толгойн баруун урд 4-5 дугуй чулуун хүрээтэй Хүннү булш байна.



- **Ханангийн энгэрийн төвд бичгийн дурсгал:** Ханангийн энгэрийн Гэр чулууны бууцны хойд талын элсэн чулуун хад бүхий толгойд 6 төвд үсэг бүхий бичээсийг сийлжээ. Энэ бичээсийн солбилцол №1. Гэр чулууны бууцнаас баруун урагш хоёр жижиг толгой байх ба баруун талын толгойн оройд 6 төвд үсэг бүхий 44 x 10-15 см хэмжээтэй бичээсийг улаан зосоор бичсэн бичээс байна.



- **Ханангийн энгэрийн дөрвөлжин булш:** Ханангийн энгэрт байх төвд бичээс бүхий толгойн урд болон баруун талаар, энд орших хиргисүүрийн эргэн тойронд нийт 15 дөрвөлжин булш байна. Булшнуудыг байгалийн энгийн чулууг дөрвөлжлөн дэвсэж болон дөрвөлжин чулуун далан үүсгэж үйлджээ. Дөрвөлжин булшнууд нь 1-4 хүртэлх тоогоороо бүлэглэн оршино.



25. Ханангийн Хөшөөнө бууцны дурсгал: Баянмөнх сумын Хэрлэн багийн нутагт, сумын төвөөс хойд зүгт 20 гаруй км-т байх урт, хад асга бүхий уулыг Ханан хэмээн нэрлэх бөгөөд бид энэ уулын дурсгалыг 2 хуваан бүртгэсэн болно. Ханан уулын дундаас баруун хэсгийг Хөшөөнө бууц гэх бөгөөд энэ хэсэгт 4 хиргисүүр, 46 дөрвөлжин булш, 4 хүннү булш цөөн тооны неолитын үеийн чулуун зэвсгийн зүйлс олдож байв.

- **Хөшөөнө бууцны хиргисүүр:** Ханангийн Хөшөөнө бууцын урд дөрвөлжин булшнуудын урд 3 хигисүүр байна.
Хиргисүүр-1 дугуй хүрээтэй, 13 орчим дагалдах байгууламжтай.
Хиргисүүр-2 саяхан тоногдсон 2 орчим метрийн гүн ухсан, дугуй хүрээтэй.
Хиргисүүр-3,4 хүрээ болон дагалдах байгууламжгүй. Хиргисүүр-4 тоногдсон байлаа.



- **Хөшөөнө бууцны хүннү булш:** Ханангийн Хөшөөнө бууцын баруун талын жалганы баруун талд орших бүлэг дөрвөлжин булшны баруун талд 4 хүннү булш байна. Булш нь дугуй чулуун далантай, голдоо үл ялиг хонхортой байх аж.
- **Хөшөөнө бууцны дөрвөлжин булш:** Ханангийн хөшөөнө бууц орчимд нийт 50 орчим дөрвөлжин булш байна. Булшнуудын 6 ширхэг нь энд орших хиргисүүрийн хажууд байгаа бол үлдсэн 40 гаруй булш нь Ханангийн энгэрээр 4-15 орчим тоогоороо бүлэглэн оршино. Булшнуудыг байгалийн нэмгэн хавтгай чулуугаар хашлага хийн дөрвөлжилж үйлдсэн байх бөгөөд буланд нь хашлагаас өндөр чулууг хөшөө байдаар суулгасан харагдана. Зарим булшны зүүн талд хөшөө босгожээ. Энд орших булшнууд нь малын бууцтай жалганы зүүн талд 3 ширхэг, Бууцны зүүн талаас жалганы баруун тал хүртэл нийт 15 дөрвөлжин булш байхаас зарим булш нь тоногдсон байв бууцан дунд 1 булш, бууцнаас баруун тийш баруун талын жалга хүртэл 7 дөрвөлжин булш, жалганаас баруун зүгт 20 орчим булш, дээрх булшнуудын нэгэн булшны зүүн талд босгосон хөшөөн дээр дээшээ харсан 3 хагас сар хэлбэрийн зураас байна.

26. Холбоо уулын дурсгал: Баянмөнх сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс урагш 27 км-т, Дулаан уулын баруун талд Холбоо хэмээх уул бий. Холбоо уулын урд энгэрээс эхлэн уулыг нар зөв тойрох замд нийт 7 хиргисүүр, 36 дөрвөлжин булш бүртгэгдлээ.

- **Холбоо уулын хиргисүүр:** Энд орших хиргисүүрүүдийн голын дараасын чулууд нь нэлээд тарсан байдагтай харагдана.
Хиргисүүр-1: Холбоо уулын зүүн Холбоогийн урд энгэрт оршино. Дугуй хүрээтэй, дагалдах байгууламжгүй, энд орших дөрвөлжин булшнуудын хажууд байна.
Хиргисүүр-2: Хүрээ, дагуул тахилын байгууламж мэдэгдэхгүй юм. Холбоо 2 уулын голын оныны урд Баруун Холбоо уулын зүүн энгэрт оршино.
Хиргисүүр-3: Холбоо уулын баруун урд талд байх нэгэн намхан толгод дээр 3 дөрвөлжин булшны хамт оршино. Дугуй хүрээтэй боловч хүрээ нь мэдэгдэх төдийл харагдаж байлаа. Холбоо уулын баруун урд энгэрийн Хиргисүүр-4 гэж бүртгэсэн дурсгалаас баруун урагш 300 метрт байх аж.
Хиргисүүр-4: Холбоо уулын баруун урд энгэрт/БаруунХолбоо/ оршино. Дугуй хүрээтэй, хажууд нь 8 дөрвөлжин булш байлаа.
Хиргисүүр-5: Уулын баруун энгэрт байна. Хүрээ болон дагалдах байгууламжгүй.
Хиргисүүр-6: Уулын хойд бэлд байна. Хүрээгүй 6 дагалдах байгууламжтай.

Хиргисүүр-7: Хүрээгүй, өмнөх хиргисүүрээс зүүн хойд зүгт 300 метрт байна. 6 дагалдах байгууламжтай.



- **Холбоо уулын дөрвөлжин булш:** Холбоо уулын дөрвөлжин булшийг уулын урд энгэрийн зүүн талаас эхлэн бүртгэлээ. Энд нийт 36 дөрвөлжин булш байна. Булшнуудыг байгалийн чулуудыг ашиглан дөрвөлжин дэвсэж үйлдсэн бол заримыг нь байгалийн энгийн чулуудаар хана хийн хайрцаглан үйлдэж, чулуугаар дарсан мөн зарим булшны ханыг хавтгай чулуудыг хайрцаглан суулгаж үйлдсэн байна. Булшнуудын дэргэд хөшөө гэхээр зүйл харагдахгүй байлаа. Булшнуудын анхны хэлбэр зохион байгуулалт тодорхой хэмжээгээр алдагдсан байна. Дөрвөлжин булшнуудыг дараах байршлаар бүртгэв.
- Зүүн Холбоо уулын урд энгэрийн дөрвөлжин булш: Энд 3 хэсэг газар 1-3 хүртэл тоогоор бүлэглэн орших нийт 6 булш байна.
- Хиргисүүр-1 ийн хажуу талын дөрвөлжин булш: Хиргисүүрээс баруун тийш 50 метрт цувраа өргөрөгийн дагуу 3 цувраа дөрвөлжин булш оршино.
- Хиргисүүр-2 ийн баруун хажуугийн дөрвөлжин булш: Баруун холбоо уулын зүүн энгэрийг баруун тийш даган явахад 2 дугаартай хиргисүүрээс 65 метрийн зайд 4 дөрвөлжин булш, булшнаас баруун тийш 50 орчим метрт 5 дөрвөлжин булш нийт 9 булш байна.
- Холбоо уулын баруун урд талын намхан толгодын дөрвөлжин булш: Энд орших хиргисүүрийн хажууд 3 дөрвөлжин булш байна.
- Уулын баруун урд энгэрийн дөрвөлжин булш: Баруун Холбоогийн баруун урд энгэрт Хиргисүүрийн урд талд 7 дөрвөлжин булш бүлэглэн оршино. /Солбилцол №7/
- Холбоо уулын арын дөрвөлжин булш: 7 дугаартай хиргисүүрийн хажууд 8 дөрвөлжин булш байна. Булшнуудын хэлбэр хэмжээ өөр хоорондоо төстэй бөгөөд байгалийн чулууг дөрвөлжлөн дэвсэж үйлдсэн байна.

27. Тэнгэр давааны хиргисүүр: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 20 км-т Язаар уулын салбар уул Адуун хориот уулын зүүн үзүүр дэх хөтлийг Тэнгэр даваа гэх бөгөөд энэ хөтөл дээр 1 дугуй хүрээтэй, дагалдах байгууламжгүй хиргисүүр байна.

28. Усан хар өндөрийн хиргисүүр: Баянмөнх сумын Баянбулаг багийн нутагт, сумын төвөөс урагш 19 км-т, Язаар хэмээх уулын салбар уул Усан хар Өндөр гэх уулын баруун болон зүүн урд бэлд 2 хиргисүүр байна. Энэхүү Усан хар өндөр уулын урд мөн Язаар уулын салбар уул болох Ичээт уул оршино.

Хиргисүүр-1: хүрээгүй, 15 орчим тахилын дагуул байгууламжтай.

Хиргисүүр-2: дугуй хүрээтэй, 3 тахилын дагуул байгууламжтай байлаа.



29. Цахиурт хар өндөрийн дөрвөлжин булш: Баянхутаг сумын Дулаан багийн нутагт, сумын төвөөс урагш 20 гаруй км-т орших Цахиурт Хар өндөр хэмээх уулын урд энгэрт 7 дөрвөлжин булш байна. Дөрвөлжин булшнуудын ханыг байгалийн энгийн чулууг ашиглан хайрцаглаж суулгаад дотор талыг чулуугаар дарж үйлджээ.



6. ӨНӨӨГИЙН БАЙДЛААР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР


Ж.ОЧГЭРЭЛ /ТӨМӨР ХИЙЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮН/ ҮЙЛДВЭРЛЭГЧ

Баянмөнх сумын 3 дугаар багийн иргэн Ж.Очгэрэл нь 2017 онд сумын “Жижиг дунд бизнесийг дэмжих сан” –аас зээл авч сумын иргэдийн захиалгын даргуу тооно төмөрлөх, хогийн утгуур, яндан, аргалын авдар, хийх зэрэг төмөр хийцийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.




С.МӨНХБАТ - /МОД, МОДОН ЭДЛЭЛ/-ИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ

Баянмөнх сумын 4 дүгээр багийн иргэн С.Мөнхбат нь 2007 оноос эхлэн мод, модон эдлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж иргэдийн захиалгаар байшингийн тодоод засал, хаалга, цонх, монгол гэрийн хаалга, идээны цар, бурханы гүнгэрваа, гэрийн тавилга зэргийг хийж үйлдвэрлэл явуулдаг. Жил бүр аймаг, сумын “Намрын баяр” үзэсгэлэн худалдаанд оролцдог. Сумын “Намрын баяр” үзэсгэлэн худалдаанд оролцож 2 жил дараалан шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарч байсан.



Б.ЗОЛЖАРГАЛ - /ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭЛ, БЛОК/ ҮЙЛДВЭРЛЭГЧ

Баянмөнх сумын 4 дүгээр багийн иргэн Б.Золжаргал нь 2006 оноос эхлэн эх бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж. Байгууллага, иргэдийн захиалгаар өргөмжлөл, батламж, тэмдэглэлт арга хэмжээний болон хурим найрын урилга, гэр бүлийн гэрэл зураг, зураг, бэлэг дурсгал, тэмцээн уралдааны цом, медаль, мандат хийх зэрэг эх бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.





Мөн блокны үйлдвэрлэл явуулж 2-3 хүнийг ажлын байраар хангаж байна.



У.ЗОЛЖАРГАЛ - /ЗӨӨВРИЙН СУУЦ/-НЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ

Баянмөнх сумын 4 дүгээр багийн иргэн У.Золжаргал нь 2016 оноос хөдөөгийн малчдын захиалгаар зөөврийн сууц хийж орон нутагтаа үйлдвэрлэл явуулж байна. Малчид зөөврийн сууцыг ихээр сонирхож худалдаж авах эрэлт ихсэж байгаа учраас орон нутагтаа зөөврийн сууц үйлдвэрлэж байгаа нь малчдад тээврийн зардал хэмнэж орон нутгаасаа авах боломж бүрдсэн. Зөөврийн сууц нь отор нүүдэл хийхэд тохиромжтой юм.





Г.ЭРДЭНЭСАРУУЛ - /АРАГ, САВАР/-НЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧ

Баянмөнх сумын 3 дугаар багийн иргэн Г.Эрдэнэсаруул нь 2005 оноос эхлэн араг, саварны үйлдвэрлэл эрхлэж байна. Уг үйлдвэрлэл нь хөдөөгийн малчдад эрэлт хэрэгцээ сайтай бүтээгдэхүүн юм.



О.ЦЭРЭННАДМИД - /ГАР УРЛАЛ, БЭЛЭГ ДУРСГАЛ/-НЫ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

Баянманх сумын 4 дүгээр багийн иргэн О.Цэрэннадмид 2007 оноос эхлэн гар урлал бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Сумын Намрын баяр арга хэмжээнд тогтмол оролцож шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарч байсан.



Б.АЛТАНЗАЯА - /СУРАН ЭДЛЭЛ/ ҮЙЛДВЭРЛЭГЧ

Баянмөнх сумын 2 дугаар багийн иргэн Б.Алтанзаяа нь оноос эхлэн үхрийн ширээр суран эдлэл /эдлэл үйлдвэрлэж хазаар, ногт, унаганы зэл, уяаны гичир, бугуйл, олом, жирэм, чөдөр/ зэргийг хийж малчдад худалдан борлуулдаг. Аймаг, сумын намрын баярын арга хэмжээнд тогтмол оролцдог. Сумын намрын баяр арга хэмжээнд оролцож шилдэг бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээр шалгарч байсан.





7. ЦААШИД ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, СУМЫН ХЭТИЙН ХӨГЖЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Хөгжүүлэх боломжтой үйлдвэрлэл үйлчилгээний чиглэл:

Ахуйн үйлчилгээний салбар:

1. Үсчин, гоо сайхан, халуун ус, саун
2. Компьютер, интернет, гэрэл зураг, эх бэлтгэлийн үйлчилгээ
3. Гутал, оёдол, цахилгаан хэрэгсэл, бусад төрлийн засвар үйлчилгээ.
4. Гар урлал, дархан, модон эдлэл,

Хөнгөн үйлдвэрийн салбар:

1. Уламжлалт аргаар арьс, шир боловсруулах цех
2. Ноос, ноосон бүтээгдэхүүн, эсий эдлэлийн цех
3. Монгол Тафтинг хивсний үйлдвэр
4. Оёдолын цех
5. Мужаан модон эдлэлийн цех
6. Блокны үйлдвэр

Хүнсний үйлдвэрлэлийн салбар:

1. Мал нядалгааны цэг
2. Сүү боловсруулах цех
3. Цагаан идээ цуглуулах, савлаж боловсруулах цех
4. Хүнсний ногоо борлуулах цех
5. Талх, нарийн боовны цех

Хөдөө аж ахуйн салбар:

1. Эрчимжсэн мал аж ахуй
2. Гахайн аж ахуй
3. Тахианы аж ахуй
4. Төмс, хүнсний ногооны тариалалт
5. Хүлэмжийн тариалалт

6. Чацаргана болон бусад төрлийн жимс, жимсгэний тариалалт
7. Тэжээлийн ургамлын тариалалт, хадлан бэлтгэл, малын тэжээлийн үйлдвэр
8. Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээ, лаборатори